

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА,  
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 он

## Оршил

1. **ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН**
2. **ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ**
  - 2.1 Дархан-Уул аймгийн 2016 оны Газрын нэгдмэл сангийн тайлан, мэдээ
  - 2.2 Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоод шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх, цахимжуулсан тайлан
  - 2.3 Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер-2” програм хангамжийн тайлан, мэдээ
  - 2.4 Геодезийн цэг тэмдэгтийн хадгалалт хамгаалалт, тооллогын ажлын мэдээ, тайлан
  - 2.5 Хаягийн мэдээллийн систем байгуулах ажлын хүрээнд хийсэн тайлан
  - 2.6 Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө, хэрэгжилт
  - 2.7 Газар эзэмшүүлэх эрхийн газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан
  - 2.8 Инженер хайгуул, фото мониторинг, газрын хянан баталгааны мэдээ, тайлан
  - 2.9 Газар өмчлөлийн мэдээ, тайлан
  - 2.10 Газрын зөрчил, маргаан түүнийг шийдвэрлэсэн байдал
  - 2.11 Газрын төлбөр, татварын мэдээ, тайлан
  - 2.12 Газрын цахим биржийн мэдээ, тайлан
  - 2.13 Газар эзэмшүүлэх эрхийн газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын мэдээ, тайлан
  - 2.14 Газрын харилцааны чиглэлээр хяналт шалгалт хийсэн ажлын тайлан

### **3. ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ**

- 3.1 Орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд
- 3.2 Шинээр ашиглалтад орсон орон сууцны барилгын борлуулалтын мэдээ
- 3.3 Барилгын хувийн хэрэг хөтлөлтийн талаар
- 3.4 Барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр:
- 3.5 Дархан-Уул аймагт баригдаж ашиглалтад орж байгаа орон сууцны барилгын эрэлт, нийлүүлэлтийн судалгаа
- 3.6 Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаар:
- 3.7 Зөрчилтэй барилга байгууламжид авсан арга хэмжээний талаар:
- 3.8 Зураг төслийн болон барилга угсралтын тусгай зөвшөөрөл шинээр авах, хугацаа сунгуулсан талаар:
- 3.9 Хот байгуулалт, дахин төлөвлөлтийн чиглэлээр
- 3.10 Гамшгаас хамгаалах байнгын ажиллагаатай зөвлөлийн чиг үүргийн дагуу хийсэн ажлын талаар:
- 3.11 Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн талаар:
- 3.12 Сорил шинжилгээний лабораторийн талаар:
- 3.13 Захиалагчийн техник хяналтын талаар
- 3.14 “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх
- 3.15 Дархан хотын бохир усны менежмент сайжруулах төсөл мон 3244/3245 төсөл

### **4. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ**

### **5. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТ**

### **6. ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ МЭДЭЭ, ТАЙЛАН**

### **7. ТӨСӨВ, САНХҮҮ, ШИЛЭН ДАНСНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

## ОРШИЛ

Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах, засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухайн нэгжийн хилийн цэсийг тодотгох, өөрчлөлт оруулах талаар гарсан саналыг зохих журмын дагуу боловсруулах, газрын кадастр эрхлэх аймгийн Газрын мэдээллийн сан байгуулж, олон нийтэд мэдээллээр үйлчлэх, газрын тайланг зохих журмын дагуу гаргаж Засаг дарга болон ГЗБГЗЗГазарт тайлагнах, нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд хийгдэх газар зохион байгуулалтын ажлыг зохион байгуулах, Засаг даргын шийдвэрийг үндэслэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай газар эзэмшүүлэх, ашиглуулах асуудлаар гэрээ байгуулж, эрхийн гэрчилгээ олгох, газрын төлбөрийг зохих хууль тогтоомжийн дагуу ногдуулж төр ард түмний хоорондын холбоог бэхжүүлэх, газар ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлт, газраас үүдэн гарах зөрчил бэрхшээлийг арилгахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллах үүрэг зорилготой.

Орон нутаг дахь хот байгуулалтын бодлогыг боловсруулахад санал гаргах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зураг төсөл хайгуул шинжилгээний ажлыг зохион байгуулах, хот суурины нутаг дэвсгэр дээр хот байгуулалтын кадастр хөтлөх, хот байгуулалтын архивын санг бүрдүүлэх, гудамжны нэр, барилгын дугаар тогтоох ажлыг зохион байгуулах, барилгын үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, аймгийн төв, сум, суурин газрын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурлан салбарын хөгжлийн хэтийн болон ойрын жилүүдэд хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийг оновчтой төлөвлөх, төсөл төсөөлөлд санал боловсруулж тусгуулахад мэргэжил арга зүй, удирдлага зохицуулалтаар хангах, холбогдох байгууллагад хүргүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллах нь бидний үндсэн үүрэг болно.



2017 онд хийсэн онцлог ажлуудаас дурдвал:

- Байгууллагын стратеги төлөвлөгөөтэй болсон.
- Дархан-Уул аймгийн хэмжээнд хаягжуулах ажлыг эрчимжүүлсэн.
- Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн ашиглалт, олборлолт явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, эвдэрсэн, нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон газрын хэмжилт, тооллого явуулан газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн.
- Байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээний баг Газрын харилцааны чиглэлээр хяналт шалгалтыг аймгийн хэмжээнд 2 удаа зохион байгуулсан.
- Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер-2” програм хангамжийг аймгийн хэмжээнд бүрэн нэвтрүүлсэн.
- Газрын дуудлага худалдааг анх удаа цахимаар зохион байгуулсан. Аймгийн орон нутгийн хөгжлийн санд 100.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 484.6 сая төгрөг төвлөрүүлж жилийн төлөвлөгөөг 485 хувиар давуулан биелүүлсэн.
- Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган шинээр төлөвлөх ажлыг эхлүүлээд байна.

## 1. ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЙЛАН

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2017 оны А/13 тушаалаар байгууллагын “Хүний нөөцийн хөтөлбөр”, “Үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлуулсан. Уг хүний нөөцийн хөтөлбөр нь 2017-2020 он хүртэл хэрэгжинэ. Хүний нөөцийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан тухайн жилийн сургалтын хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, 2017 оны сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллалаа.

➤ 2017 оны 02 дугаар сарын 14-ны өдөр үр дүнгийн гэрээ төрийн захиргааны 12 албан хаагчидтай, төрийн үйлчилгээний 6 албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээг ёслол төгөлдөр хүндэтгэлтэй байгуулсан.



Үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн /2017.06.15, 2017.12.08/ жилээр дүгнэх ажлыг байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний баг зохион байгуулж ажилласан.

2017 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар 18 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа ба албан хаагчдын 33,3 хувь буюу 6 эмэгтэй, 66,6 хувь буюу 12 эрэгтэй, харин сумдын даамлуудын 100 хувь буюу 3 эмэгтэй албан хаагч тус тус ажиллаж байна.



ажлын байрны орчны хими, физикийн хүчин зүйлд шууд хэмжилтийг хийж дүгнэлтийг хүргүүлсэн.




Дүгнэлтээр хэмжилт хийсэн ажлын байрны чийглэг 30-60 хувь, агаарын урсгалын хурд 0,1м/с байх нормоос бага, агаар хуурай, агаарын хөдөлгөөнгүй байгаа нь хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл мэнд, хөдөлмөрийн эрүүл ахуй, ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2015 стандартын 5.1 дэх заалтын хэмжээг хангахгүй байна.

Мөн Архивын өрөөний температур 24.8 хэм, чийглэг 18 хувь байгаа нь байгууллагын архивын үндсэн зааврын 4.3.2.1 дэх заалтын температур +14 хэмээс +16 хэм, чийглэг 50-55 хувь байх шаардлагыг хангахгүй байна гэсэн тус тус дүгнэлт гарсан бөгөөд бусад хэмжилтийн үзүүлэлтүүд нь хэвийн байна гэсэн дүгнэлт гарсан.

Тус дүгнэлт болон байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж эхний ээлжинд байгууллагын архивын өрөөний аюулгүй байдал, стандарт, зай хэмжээ, талбай, хадгаламжийн нэгжийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулж Архивын өрөөг шилжүүлэн нүүлгэж, модон хаалгатай байсныг төмөр хаалгаар сольж шинэчилсэн.



*Өрөө шилжүүлсэн байдал*



*Модон хаалгатай байсан*



*Төмөр хаалга болсон*

➤ ГХБХБГ-ын 2017 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/14 тоот тушаалаар ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрмийг 1 дүгээр хавсралтаар, Авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар

хавсралтаар тус тус батлуулсан. Газрын удирдлагын хэлтсийн дарга шинээр томилогдсонтой холбоотой Хөрөнгө орлогын мэдүүлгийг хүлээн авч 30 хоногийн дотор бүртгэж баталгаажуулсан. Байгууллагын албан хаагчдын ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлсэн мэдэгдэл 2017 оны 12 сарын 01-ний байдлаар 91 байна.

Мөн Авлигатай тэмцэх газры ажлын хэсэг Дархан-Уул аймагт 2017 оны 11 дүгээр сарын 20-24-ны хооронд ажиллаж, энэ хугацаанд байгууллагын холбогдох чиглэлүүдээр хяналт шалгалтыг хийж, 25 судалгааны маягтын дагуу мэдээллүүдийг цаасан болон файлаар хүргүүлсэн.

➤ Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулж буй “Хүн амын бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын сарын аяны хүрээнд 499хаагчид бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хурд, хүч, тэсвэр, уян хатан, тэнцвэр, авхаалж самбаа гэх мэт үндсэн 10 үзүүлэлтээр сорилыг аймгийн Биеийн тамир спортын газрын багш, дасгалжуулагч Б.Ховор-Эрдэнэ, Х.Батбаяр нар авсан.



➤ **Хүний нөөцийн чиглэлээр 2017 онд шинээр боловсруулсан бичиг баримтууд:**

1. Хүний нөөцийн хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө /2017.04.10 №А/13/
2. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ёс зүйн дүрэм, авлигатай тэмцэх, шударга ёс, ил тод байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө /2017.04.10 №А/14/
3. Байгууллагын 2017 оны сургалтын төлөвлөгөө /2017.04.10/
4. Байгууллагын санал хүсэлт хүлээн авах журам /2017.03.21 №А/07/
5. Түр орон ажиллах тухай тушаал, хуваарь /2017.05.31 №Б/16/



6. Цаг ашиглалтад хяналт тавих журам /2017.08.14 №А/25/
7. Газар эзэмших ашиглах гэрээ дүгнэх журам /2017.09.07 №А/30/
8. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2017 оны ажлын төлөвлөгөө /2017.11.13/

## 2. ТАЙЛАНТ ОНД ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ТАЛААР ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

### 2.1 Дархан-Уул аймгийн 2016 оны Газрын нэгдмэл сангийн тайлан

Аймгийн 2016 оны газрын нэгдмэл сангийн тайланг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 12 дугаар тогтоолоор дүгнэлт гаргуулан ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. 2017 оны газрын нэгдмэл сангийн тайланг 2018 оны 01 дүгээр сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

### 2.2 Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоод шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх, цахимжуулсан тайлан

Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх, цахимжуулах ажлын хүрээнд 2017 онд аймгийн хэмжээнд 491 нэгж талбарын зөрчлийг арилгаж, 7795 нэгж талбарыг цахимжуулсан байна.

- ✚ Тус ажлын хүрээнд хийгдсэн **77482** цаасан суурьтай мэдээллийг хүлээн авсан.  
Үүнд:

- Дархан сум - 53934
- Шарын гол сум - 6124
- Орхон сум - 11043
- Хонгор сум - 6381



- ✚ Гэрээт ажил хүлээлгэж өгснөөс хойш **24124** цаасан суурьтай мэдээлэл үүссэн байна.  
Үүнд:

- Дархан сум - 19483
- Шарын гол сум - 907

- Орхон сум - 1689
- Хонгор сум - 2045


### 2.3 Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер-2” програм хангамжийн тайлан, мэдээ

- 2017 оны 2 дугаар сард “Топ маф” ХХК, ГЗБГЗЗГазарт Лэнд менежер-2 програм хангамжийн шинэ хувилбарын туршилтын сургалтад суусан.
- ГЗБГЗЗГ-ын даргын 2017 оны А/139 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын кадастрын мэдээллийн сан ажиллуулах журам”-ын 4.4.3-т сумдын Газрын даамлууд мэдээллийн сангийн програм хангамжийн сургалтад хамрагдаж, батламж авсан байна гэж заасны дагуу 2017.05.04-2017.05.07-ны хооронд Шарын гол, Хонгор, Орхон сумдын газрын даамлуудад Лэнд менежер-2 програм хангамжийг нэвтрүүлэх сургалт зохион байгуулсан.



“Лэнд менежер-2” програмын сургалт

Лэнд менежер-2 програмын сургалтыг газрын даамал нарт явуулснаас хойш онлайн хичээл буюу TeamViewer програмын тусламжтайгаар өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглах, гарсан алдаа дутагдлыг тухай бүрт нь засаж залруулах ажилд тухай бүрт хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд Лэнд менежер-2 програм хангамж бүрэн нэвтэрсэн ба 2017 онд нийт 2125 газрын кадастрын зурган мэдээллээр үйлчилсэн байна.




TeamViewer програм хангамж

## 2.4 Геодезийн цэг тэмдэгтийн хадгалалт хамгаалалт, тооллогын ажлын мэдээ, тайлан

“Геодези, зураг зүйн тухай” хуульд зааснаар геодезийн байнгын цэг, тэмдэгт нь төрийн өмч бөгөөд түүнийг хадгалж, хамгаалах нь сум, дүүрэг, хил хамгаалах байгууллагын үүрэгт хамаарах учраас түүнийг орон нутгийн өмчид шилжүүлэх ажлын бэлтгэлийг хангах зорилгоор геодезийн байнгын цэг, тэмдэгтийн судалгаа хийж, цэг бүрийн хувийн хэргийг бүрдүүлж, тооллого явуулах ажлыг хийж гүйцэтгэхээр ГЗБГЗЗГ-аас шийдвэрлэсэн билээ.

➤ Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг орон нутгийн үндсэн хөрөнгөд үнээр нь бүртгэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын захирамжаар геодезийн цэг тэмдэгтийн тооллого явуулах ажлын хэсэг байгуулан ажилласан. Эхний ээлжинд Дархан сумын нутаг дэвсгэрт байрлах **83** цэг тэмдэгтийг газар дээр нь явж тооллого судалгаа хийсэн. ГЗБГЗЗГ-аас ирсэн албан бичгийн хавсралтад дурдагдсан цэг тэмдэгтийн тоо хэмжээг өмнө актаар хүлээлгэн өгсөн цэг тэмдэгтийн тоо хэмжээтэй харьцуулан жагсаалт үйлдсэн бөгөөд Аймгийн хэмжээнд байгаа нийт цэг тэмдэгтийн бүртгэлийг нэгтгэж ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.



*Дархан сум*

*Орхон сум*

*Хонгор сум*

*Шарын гол сум*

Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдуудад актаар хүлээлгэж өгсөн нийт **147** цэг тэмдэгтийн бүртгэл байдаг. Сумын төвүүд дээр байрлах цэг тэмдэгтүүийг акттай нь тулган, сумдын даамлууд судалгааг газар дээр нь явж хийсэн. Судалгаагаар:

- Орхон суманд - **11** /2013 онд “Геосурвэй” ХХК хийсэн байр зүйн болон кадастрын өөрчлөлтийн зураглал хийхэд тоологдсон/
  - Шарын гол суманд - **5**
  - Хонгор суманд - **62**
  - Дархан суманд - **83** цэг тоологдсон.

Дархан сумын төв болон төвийн ойролцоо байгаа **83** цэгээс **21** цэгийг гэмтээж устгасан нь тогтоогдсон.



Цэг тэмдэгтийг гэмтээж устгасан этгээдийг олж хариуцлага хүлээлгэх ажлыг зохион байгуулж байгаа боловч тодорхой үр дүнд хүрэхгүй байна. Устгасан эзэн тодорхой бус байгаа тул нөхөн сэргээхэд гарах зардлыг төлүүлэх боломжгүй, орон нутгийн төсөвт нөхөн сэргээхэд гарах хөрөнгө тусгагдаагүй зэрэг хүндрэлтэй асуудлууд үүсээд байна. Устсан цэгүүд GNSS-ийн байнгын ажиллагаатай станцын долгион цацах хүрээн дотор байршилтай байгаа зэрэг нөхцлүүдийг харгалзан эдгээр цэгүүдийг актлаж өгөх саналыг ГЗБГЗЗГ-т хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



➤ “Монгол улсын гравиметрийн сүлжээг шинэчилж, сайжруулах” техникийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Дархан-Уул аймагт байрлах гравиметрийн сүлжээний цэгийн /035/ хээрийн судалгаа, хэмжилтийг хийж гүйцэтгэлээ. Дархан-Уул аймагт гравиметрийн сүлжээний /035/ цэг 1 ширхэг байдаг ба тухайн цэг нь Орхон сумын 2-р баг Ноёнхонгорт, хуучин нисэх буудал байсан газарт байрладаг. Цэгийн хэмжилтийн нөхцөл хэвийн байгаа ба цэг тэмдэгтийн хувийн хэргийг шинээр хөтлөн хэмжилтийн үр дүнгийн хамт 2017 оны 09 сарын 18-ны №676 тоот албан бичгээр ГЗБГЗЗГ-т хүргүүллээ.

Одоогийн байдлаар уг цэгийн хэмжилт хийх нөхцөл хэвийн байгаа боловч цэгийг тойруулан тариалангийн зориулалтаар газар олголт хийсэн байгаа нь цаашид устах нөхцөл бий болоод байгаа тухай Орхон сумын Засаг даргад 2017 оны 09 сарын 12 нд №651 тоот албан бичиг хүргүүлсэн.




➤ Дархан-Уул аймагт байрлах нийт 147 геодезийн байнгын цэг тэмдэгтээс Хонгор сумын нутагт байрлах цэгээс **46** цэг Засгийн газрын 2009 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан солбицлын тогтолцоонд Газрын даргын 2014 оны А/112 дугаар тушаалаар батлагдсан эринд шилжигдээгүй тухай 2016 онд ГХГЗЗГ-т албан бичиг хүргүүл байсан. Одоогийн байдлаар бүх цэг шинэ эринд шилжигдсэн ба тэгшитгэн бодолт хийгдэж байгаа тул материалыг ГЗБГЗЗГаараас ирүүлээгүй байна.

➤ Байнгын ажиллагаатай станцыг олон улсын стандартад нийцүүлэн газарт шилжүүлэн суулгах шаардлагын дагуу Дархан суманд байрлах байнгын ажиллагаатай станцыг шилжүүлэх байршлыг сонгон орон нутгийн “Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-тай тохиролцон тухайн газарт RTK болон бодит агшины хэмжилт хийн шалгаж саналыг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Үүний дагуу станцыг шилжүүлэн суурилуулах ажил хийгдэж дууссан ба Жи мобайлын Nr-10 Router авч холболт хийсэн. “Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-ий шилэн кабельтай холбож үйл ажиллагаа явуулж эхэлсэн боловч станцын сүлжээнд байнга доголдол гарах болсон. ГЗБГЗЗГ-аас “Мэдээлэл холбоо сүлжээ” ТӨХК-ий интернетийн сүлжээ нь доголдолтой байна гэсэн тул Жи мобайлын хуучин Nr-10 Routerтэй буцааж холбон ажиллаж байна.



➤ Тариалангийн бүс нутаг, түүний хил заагийг тогтоох асуудлыг Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэх ажлын хүрээнд “ Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хосолсон тариалангийн төв бүс нутаг“, “ Мал аж ахуй, газар тариалан хосолсон бүс нутаг “ гэсэн 2 ангиллаар бүс нутаг тогтоох саналыг оруулахаар зураг төслийг хийж, 2017 оны 03 дугаар сарын 28-нд Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар баталж тогтоол гаргасан.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдын 2009 оны 05 сарын 14-ны өдрийн №36 тоот тогтоолоор Дархан –Уул аймгийн газар нутгийг **“ эрчимжсэн мал аж ахуй, газар тариалангийн бүс ”** болгон тогтоосон байна.




Дархан-Уул аймгийн “ Хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого ”-ын хүрээнд:

- ❖ Дархан-Уул аймгийн баруун хилийн шугамын дагуу Хонгор, Орхон сумдын газар нутгийг оруулан зүүн тийш Зулзаагийн гол хүртлэх 166.7 мянган га газрыг “ Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хосолсон тариалангийн төв бүс нутаг ”
- ❖ Зулзаагийн голоос зүүн тийш Дархан-Уул аймгийн зүүн хилийн шугамын дагуух 136.3 мянган га газрыг “ Мал аж ахуй, газар тариалан хосолсон бүс нутаг ” болгон баталуулах саналыг оруулж байна.

Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хосолсон тариалангийн төв бүс нутагийн хил заагийн зураг.

166.7 мянган га газрыг хамрах “Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хосолсон тариалангийн төв бүс нутаг”-ын хилийн шугам.



**Урд талаараа:** Шарын гол сумын хилийн цэсний 988.2 тоот өндөрлөгөөс баруун тийш Хонгор сумын урд хилийн шугамын дагуу Харва голын 8-р цэвэр хойшоо Хонгор сумын хилийн шугамыг /Харва голоор/ Ухаа хушууны гүүр хүртэл, Ухаа хушууны гүүрээс Дархан сумын зүүн талын хилийн шугамын дагуу Их Булгийн уул хүртэл, Их Булгийн уулаас баруун тийш Дархан сумын хойд хилийн шугамыг Ногоон модны гүүр хүртэл, Ногоон модны гүүрээс хойшоо Орхон сумын зүүн хилийн шугамын дагуу Харва-Орхон голын бэлчир хүртэл, Харва-Орхон голын бэлчирээс зүүн хойшоо Орхон сумын хилийн шугамыг /Орхон голоор/ Орхон-Ерөө голын бэлчир хүртэл, Орхон-Ерөө голын бэлчирээс зүүн тийш Ерөө голоор Ерөөгийн гүүр хүртэл.


**Зүүн талаараа:** Ерөөгийн гүүрээс урагш Дархан-Сэлэнгийн авто замаар Засмал замын 245 дахь километрийн цэнг хүртэл.

**Хойд талаараа:** 245 дахь километрийн цэнгээс зүүн тийш Хүйтэнгийн голын 693.4 тоот өндөрлөг хүртэл, 693.4 тоот өндөрлөгөөс Хүйтэнгийн голоор зүүн тийш Хүйтэн-Зулзаагийн голын бэлчир хүртэл.

**Зүүн талаараа:** Хүйтэн-Зулзаагийн голын бэлчирээс урагшаа Зулзаагийн голоор Шарын гол сумын хойд хилийн цэг Олон хотол хүртэл, Олон хотолөөс урагшаа Шарын гол сумын баруун хилийн шугамын дагуу 988.2 тоот өндөрлөг хүртэл.

Мал аж ахуй, газар тариалан хосолсон бүс нутаг

136.2 мянган га газрыг хамрах “Мал аж ахуй, газар тариалан хосолсон бүс нутаг”-ийн хилийн шугам.



**Урд талаараа:** Хонгор сумын зүүн урд талын хилийн цэсний цэг Хар модот /1649.77 /-оос баруун тийш хилийн шугамын дагуу Шарын гол сумын хилийн цэсний цэг Ногоон хушуу хүртэл, Ногоон хушуугаас хойшоо Шарын гол сумын зүүн хилийн шугамын дагуу Олон хотол хүртэл, Олон хотолөөс баруун тийш Зулзаагийн гол хүртэл.

**Баруун талаараа:** Зулзаагийн голоор хойшоо Хүйтэн-Зулзаагийн голын бэлчир хүртэл.


**Хойд талаараа:** Хүйтэн-зулзаагийн голын бэлчирээс зүүн тийш Хонгор сумын хойд хилийн шугамын дагуу Хонгорын даваа хүртэл.

**Зүүн талаараа:** Хонгорын даваанаас урагшаа Хонгор сумын зүүн хилийн шугамын дагуу Хар модот /1649.77/ хүртэл.

Дархан-Уул аймгийн “Хөдөө аж ахуйн салбарыг 2021 он хүртэл хөгжүүлэх нэгдсэн бодлого”-ын хүрээнд:

- ❖ Дархан-Уул аймгийн баруун хилийн шугамын дагуу Хонгор, Орхон сумдын газар нутгийг оруулан зүүн тийш Зулзагын гол хүртлэх 166,7 мянган га газрыг “Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй хосолсон тариалангийн төв бүс нутаг”
- ❖ Зулзагын голоос зүүн тийш Дархан-Уул аймгийн зүүн хилийн шугамын дагуух 136.3 мянган га газрыг “Мал аж ахуй, газар тариалан хосолсон бүс нутаг” болгон баталуулах саналыг оруулж байна.

➤ Мал бүхий иргэдийг хотоос гаргаж сууршуулах ажлын хүрээнд судалгаа хийж Хонгор сумын 1 дүгээр баг Талын толгойд 20.0 га газарт хэмжилт хийлээ.



➤ 2017 оны 01 дүгээр сарын 30-31 хооронд хэмжилтийн багажийн баталгаажуулалтыг Улаанбаатар хотод хэмжил зүйн лабораторид хийлгэсэн.

Хэмжил зүйн лабораторийн гэрчилгээ



Багаж баталгаажуулалтын гэрчилгээ


➤ Дархан-Уул аймгийн 3 үйлдвэр технологийн паркийн зургийг солбицол, координатаар нь гаргасан.

Дархан-Уул аймгийн үйлдвэр технологийн паркийн зураг



➤ Дархан-Уул аймгийн хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст “ҮЙЛДВЭР ТЕХНОЛОГИЙН БҮС”-ийн инженерийн шугам сүлжээний зай хэмжээний зургийг гаргаж хүргүүлсэн.


“Үйлдвэр технологийн бүс”-ийн инженерийн шугам сүлжээ



➤ Улаанбаатар хотоос Дархан хот хүртэлх босоо чиглэлийн, эхний ээлжинд хийгдэх 30км хатуу хучилттай авто замын трассын зурагтай танилцаж, саналаа тусгуулсан. Мөн авто замын трассд орсон газар эзэмшигчдийн судалгааг гаргаж, зураг төсөл гүйцэтгэгч “МСРСgr” ХХК-д хүргүүлээ.



Газар чөлөөлтийн ажлын зураг



➤ Дархан сум, 10-р баг, 25-р хороололд шинээр хийгдэж байгаа авто замын төлөвлөлтийн зургийг газарт буулгаж хяналтын хэмжилт хийсэн.

Авто замын төлөвлөлтийн зураг



## 2.5 Хаягийн мэдээллийн систем байгуулах ажлын хүрээнд хийсэн тайлан

2017 оны онцлох ажлын нэг нь Дархан-Уул аймгийн хэмжээнд хаягжуулах ажлыг эрчимжүүлэх, ахиц гаргах явдал байсан бөгөөд энэ тал дээр нилээд ажлыг зохион байгуулж ажиллалаа.

➤ 2017 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр хаягжуулалтын ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Аймгийн Засаг даргын орлогч Г.Ганболдтой уулзаж Хаягжуулалтын талаар хийж байгаа ажлаа танилцуулсаны үндсэн дээр аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар яаралтай оруулж танилцуулах шаардлагатай гэж үзсэн.



*Засаг даргын орлогч Г.Ганболдод "Хаягжилтийн ажлын явцыг танилцуулав.*

Мөн 2017 оны 01-р сарын 18-ны өдөр Дархан сумын ИТХ-ын Төлөөлөгчдөд "Хаягжуулалтын тухай" хууль, журам, стандарт, мөн Дархан сумын хэмжээнд хийгдсэн хаягжуулалтын ажлын талаар мэдээлэл хийж, төлөөлөгчдийн санал хүсэлтийг сонслоо.

Аймгийн Засаг даргын зөвлөлд Дархан сумын **28** гудамж, үүнээс **19** гудамжийг шинээр нэрлэх, хуучин нэршилтэй байсан **10** гудамжны нэрийг тодотгох сэргээх, нэрэмжит талбай болон цэцэрлэгт хүрээлэнгийн **3**, цогцолбор **3** газруудын нэр, нэршлийг сэргээх, ажлын явцыг танилцуулснаар аймгийн хэмжээнд хаягжуулалтын ажлыг эрчимжүүлэн орон тооны бус ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2017 оны 01 сарын 26-ны А/37 дугаар захирамжаар Дархан сумын Засаг даргаар ахлуулан байгуулсан.

Ажлын хэсэг 2017 оны 02 дугаар сарын 10, 15-нд 2 удаа хуралдсан. Хуралдаанаар зарим нэг гудамж цогцолбор газруудыг нэрэмжит болгох саналыг ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хэлэлцэж, шийдвэрлэсэн ба хаягжуулах журмын дагуу тоо оролцон нэрлэгдсэн 15 дугаар багийн **1-10** дугаар хэсэг, 7 дугаар багийн **017**-ийн гудамжны нэршлийг багийн ИНХ-аас гаргасан санал болон ажлын хэсгийн гишүүдээс гаргасан саналыг нэгтгэн боловсруулж, 2017 оны 02 дугаар сарын 20-нд Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулж хэлэлцүүлсэн.

Аймгийн Засаг даргын зөвлөлд ажлын хэсэг хийж гүйцэтгэсэн ажлаа танилцуулснаар аймаг, сумын ИТХ-д уламжилж тогтоол гаргуулахаар шийдвэрлэсэн. Үүний дагуу:

➤ Дархан сумын ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны **20** дугаар тогтоолоор Дархан сумын төв гудамжнуудын нэр, байршил, хил заагийг дэмжсэн, **22** дугаар тогтоолоор 15 дугаар багийн 1-10 дугаар хэсгүүдэд, 6 дугаар баг 017-ийн гудамжинд шинээр нэр олгож тогтоол гарсан.

Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны  
03 сарын 15-ны 20 дугаар тогтоолын хавсралт

д/д	Баг	Гудамжны нэр	
		Хуучин	шинэ
1	Дархан сум 15 дугаар баг	1,3 дугаар хэсэг	"Батальон"-ы гудамж
2		2 дугаар хэсэг	"Хүрээлэн"-ын гудамж

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

3		4 дүгээр хэсэг	“Овоот”-ын гудамж
4		5,6 дугаар хэсэг	“Ургац”-ын гудамж
5		7 дугаар хэсэг	“Нисэх”-ын гудамж
6		Хабитатын хэсэг	“Талын толгойн” гудамж
7		9 дүгээр хэсэг	“Бэрх уул”-ын гудамж
8		10 дугаар хэсэг	“Асгат”-ын гудамж
9	Дархан сум 7 дугаар баг	017-ийн гудамж	“Баян уул”-ын гудамж

Мөн Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 35 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар Дархан сумын төв гудамжууд, 2 дугаар хавсралтаар цогцолбор газар, нэрэмжит талбай, цэцэрлэгт хүрээлэнгийн нэр, байршил, хил заагийг баталсан.

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны  
04 дүгээр сарын 17-ны 35 дугаар тогтоолын 1-р хавсралт

№	Гудамжны байршил, хил, зааг	Гудамжны нэр	Зай /м /
1	Аймгийн Засаг даргын тамгын газраас хойшоо “Барилгачдын өргөн чөлөө”-ний замын уулзвар хүртэл.	Бурхантын гудамж	1847,9
2	Хуучин хорооллын 39 дугаар байрны урд талын замын уулзвараас зүүн тийш АШУҮИС-ийн замын уулзвар хүртэл.	ДСЦТСүлжээ ХК-ий нэрэмжит “Жаргалантын гудамж”	659,8
3	АШУҮИС-ийн ар талын замын уулзвараас хойшоо шинэ хорооллын 27-р байрны зүүн хойт замын уулзвар хүртэл.	Хөдөлмөрийн баатар Г.Тэгшжавын нэрэмжит “Эрчим хүчний гудамж”	1033,5
4	“Номин” худалдааны төвийн зүүн талын замын уулзвараас Дархан-Улаанбаатарын чиглэлийн замын уулзвар хүртэл.	Олимпийн гудамж	1629,7
5	Залуучууд театр руу эргэдэг замын уулзвараар хойшоо Дархан их дэлгүүрийн баруун талаар Ардын өргөн чөлөөний зам хүртэл.	Тамирчдын гудамж	385,0
6	Хуучин хорооллын “Үйлчилгээний төв”-ийн зүүн урд уулзвараас баруун тийш 4 дүгээр цэцэрлэг хүртэл.	Хотын дарга асан Ч.Сүрэнгийн нэрэмжит “Багачуудын гудамж”	572,6
7	“Киви” зочид буудлын уулзвараас зүүн хойш “Нүүдэлчин” эмнэлэгийн зүүн уулзвар хүртэл.	Архитектор Б.Чимэдийн нэрэмжит “Бууралын гудамж”	453,2
8	Аюулгүйн тойргоос зүүн тийш шинэ хороололын 27 дугаар байрны зүүн талын уулзвар хүртэл.	Үндэсний эрх чөлөөний гудамж	1677,4
9	16-н давхарын уулзвараас “Дархан хүнс” ХХК-ийн арын уулзвар хүртэл.	Ардын өргөн чөлөөний гудамж	4353,1
10	“Мөнгөн хөөс” авто угаалгын газрын урд замын уулзвараас баруун ургаш ОБГ хүртэл.	Генерал Д.Бавуугийн нэрэмжит “Эх орончдын гудамж”	446,0
11	Вокзал руу эргэдэг замын уулзвараас баруун тийш Барилгачдын өргөн чөлөөний шинэ замын уулзвар хүртэл.	Төр нийгмийн зүтгэлтэн Ю.Цэдэнбалын нэрэмжит “Хуульчдын гудамж”	904,9
12	Вокзалын уулзвараас хойшоо “Дархан” дээд	Давхарын өртөөний гудамж	793,4

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

	сургууль хүртэл, Дархан дээд сургуулиас “Турк” сургуулийн зүүн талын замын уулзвар хүртэл .		
13	“Россия” зочидбуудлынзүүнхойтталынуулзвараасбаруунтийш Төмөрзамын 34 дүгээрбайрхүртэл.	Ган замчдын гудамж	295,5
14	“Буян” захын баруун талын замын уулзвараас баруун тийш 15 дугаар сургууль хүртэл.	Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит “Худалдааны гудамж”	295,6
15	“Дархан хүнс” ХХК-ны урд талын замын уулзвараас бауун тийш “Ариун амгалан” ХХК урд замын уулзвар хүртэл.	Атарчдынгудамж	498,7
16	“Шунхлай” ХХК-ны ШТС-аас баруун тийш наадмын талбай хүртэл.	Наадамчдын гудамж	1464,6
17	Шүүх руу эргэдэг замын уулзвараас хойшоо “Шунхлай” ХХК-ны ШТС хүртэл.	Улан Үдэхотын нэрэмжит “Залуусын гудамж”	1455,4
18	АУИС-ийн хойд талын замын уулзвараас зүүн тийш ТИС хүртэл.	Оюутны гудамж	721,2
19	16-н давхарын урд замын уулзвараас зүүн урагшаа хуучин нисэх хүртэл.	Мангиртын гудамж	1905,5
20	“Хүслийн хотхон”-ны зүүн хойт талаас Дархан захын зүүн талын замын уулзвар хүртэл.	Барилгачдын өргөн чөлөө	2900,4
21	“Оюуны ирээдүй” цогцолбор сургуулийн урд замын уулзвараас зүүн хойшоо Барилгын өргөн чөлөөний замын уулзвар хүртэл.	Комисар Д.Пэлжээгийн нэрэмжит “Хөгжлийн гудамж”	457,1
22	Аюулгүйн тойргоос Дархан-Улаанбаатарын замаар урагшаа Төмөрлөг руу эргэдэг замын уулзвар хүртэл.	Ардын хувьсгалын өргөн чөлөө	6626,3
23	“Нар хажид” сүмийн уулзвараас баруун тийш 2 дүгээр хорооллын голоор хойшоо Олимпийн гудамж хүртэл.	Дархан Нэхий ХК-ий нэрэмжит “Нүүдэлчдийн гудамж”	712,2
24	АУИС-ийн хойд замын уулзвараас үйлдвэрийн район руу давдаг замаар Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замын уулзвар хүртэл.	Үйлдвэрчний гудамж	4602.0
25	Дархан захын зүүн урд шинэ замын уулзвараас хойшоо Дархан-Сэлэнгийн замын уулзвар хүртэл.	Зүүн дэнжийн гудамж	1631,2
26	16-н давхарын уулзвараас зүүн тийш УГТСЭШХ , ургашаа Мангиртын замын уулзвар хүртэл.	Хүрээлэнгийн гудамж	1099,1
27	Наадмын талбайн зүүн уулзвараас Хараа голын гүүр хүртэл.	Хараагийн гудамж	1432.0
28	Төмөр замын ДЕПО-ийн зүүн талын замын уулзвараас хойшоо Петровисийн ШТС хүртэл.	Улаан толгойн гудамж	1773.0

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны  
04 сарын 17-ны 35 дугаар тогтоолын 2-р хавсралт

№	Нэрэмжит талбай, цэцэрлэгт хүрээлэн, цогцолбор газрын, нэр	Байршил, хил, зааг	Талбайн хэмжээ /м <sup>2</sup> /
1	Найрамдал талбай	“Залуучууд” театрын өмнөх талбай.	11586,0
2	“Миний Монгол” цэцэрлэгт хүрээлэн	Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замын зүүн талд.	387020,0
3	“Дархан дулааны цахилгаан станц” ТӨХК-ны нэрэмжит талбай	“Номин худалдааны төвийн баруун хойд талд Талбайн хэмжээ 5500 м2	5500.0
4	Бурхан багшийн сэрэг дүр цогцолбор	Аюулгүйн тойргийн баруун талын толгой дээр.	3147,0

5	Морин хуурийн хөшөөт цогцолбор	Аюулгүйн тойргийн зүүн талын толгой дээр.	14489,0
6	Дархан – 50 цогцолбор	“ Мэдээлэл холбоо сүлжээ “ ТӨХК-ны урд талд.	32372,0

Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 35 дугаар тогтоол шийдвэрийг үндэслэн Дархан сумын хаягийн зургийн мэдээллийн санд өөрчлөлт хийж өгөхийг хүссэн албан бичгийг ГЗБГЗЗГ-т 2017.05.02-ны №335 тоотор хүргүүлсэн. Хаягийн зураг хийсэн “Геокад” ХХК ажлаа дуусгаж ГЗБГЗЗГ-т хүлээлгэн өгсөн тул Дархан сумын хаягийн зурагт өөрчлөлт хийх боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.

Уг тогтоолуудтай уялдуулан “Геокад” ХХК-ий хийсэн хаягийн зурагт байгаа зарим гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн нэр, дугаарыг өөрчлөх шаардлага гарсан тул аймгийн болон сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын тогтоолын дагуу гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн нэр дугаарын мэдээллийг Дархан сумын хаягийн зурагт шинэчлэн оруулах ажлыг хийж гүйцэтгэлээ. Шинэчилсэн Дархан сумын хаягийн зургийг 2017 оны 11 сарын 23-нд №965 тоот албан бичгийн хамт ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

ГЗБГЗЗГ-аас Хонгор, Орхон, Шарын гол сумдын хаягийн зургийг хүлээн авч сумдад хүргүүлсэн. ГЗБГЗЗГ-аас ирсэн зөвлөмжийн дагуу газар эзэмших, ашиглах эрх шилжүүлсэн, гэрээ, гэрчилгээ шинэчлэх зэрэг тохиолдолд шинэ хаяг дугаар олгох зарчмыг баримтлан Дархан суманд 26 иргэн, аж ахуйн нэгжид шинэ хаяг дугаар олгон ажиллалаа. Дархан сумын багуудын хаягийн зургийг JPEG файлаар багуудад өгч байна.



➤ Журамд заасны дагуу хаягийн тэмдэгтийг үйлдвэрлэх, байршуулах хөрөнгийн тооцоо, судалгааг гарган нийт 159.1 сая төгрөгийг 2018 оны орон нутгийн төсөвт тусгуулахаар

аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

Үүнд:

- Дархан сумын 9-16 дугаар баг- 94.8 сая төгрөг
- Хонгор сумын төв, Салхит, Цайдам – 25.3 сая төгрөг
- Орхон сум – 13.6 сая төгрөг
- Шарын гол сум -25.4 сая төгрөг байна.

Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдын 1:100 000 масштабтай байр зүйн зураг /1968/, газар зүйн нэрийн зураг /1982/, “Геокад” ХХК-ий хийсэн хаягийн зураг /2016/-т оруулсан газар зүйн нэрийг түүвэрлэн харьцуулалт хийж мэдээллийн санд бүртгэсэн ба газар нутгийн нэрийг нэрлэж хэвшүүлэх, нэр байхгүй бол шинээр өгөх, нэрийг хэлэлцүүлэн гарсан шийдвэрийг ирүүлэх, улс, орон нутгийн чанартай авто замуудын чиглэл, түүх соёл, байгалийн дурсгалт газар зэрэг нэрийн зурагт ороогүй орхигдсон объектийн мэдээллийг ирүүлэх тухай №370 албан бичгийг сумдад 2017 оны 05 дугаар сарын 15-нд хүргүүлсэн. Орхон сумын газар зүйн нэрийн түүвэр хийж /3-н зураг харьцуулан/ мэдээллийн сан байгуулсан.


- ✓ 1:100000-ны байр зүйн зурагт /1968/- 28 нэр
- ✓ Газар нутгийн нэрийн зурагт /1983/-103 нэр
- ✓ Хаягийн зураг / Гео кад 2016 /- 57 нэр

## **2.6 Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө, хэрэгжилт**

2017 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг аргачлалын дагуу боловсруулан батлуулж, аймгийн хэмжээнд хэрэгжилт 71 хувийн гүйцэтгэлтэй явж байна.

Үүнд:

- Дархан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 19 дүгээр тогтоолоор батлуулж хэрэгжилт 82,3 хувь,
  - Орхон сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 4/05, 26 дугаар тогтоолоор батлуулж хэрэгжилт 63,3 хувь,
  - Хонгор сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 02/12, 2017 оны 05/01 дүгээр тогтоолоор батлуулж, хэрэгжилт 48,8 хувь,
  - Шарын гол сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 05 дугаар тогтоолоор баталж, хэрэгжилт 89 хувьтай байна.
- 2017 оны Дархан-Уул аймгийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөг сурталчлах ажлыг шинэлэг байдлаар pubhtml5 програм ашиглан хийж, байгууллагын цахим хуудас болон фэйс бүүк хуудсаар сурталчлах ажлыг ил тод нээлттэй явуулж байгааг иргэдийн зүгээс сайшаан дэмжиж байна.



Мөн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг албан байранд зурагт хуудас, ТВ-ээр, “Нээлттэй хаалга”-ны өдөрлөгөөр, орон нутгийн ТВ болох Лха, А Жи Би, Ди Би Эс ТВ-ээр тус тус сурталчилан ажиллалаа.

➤ Дархан-Уул аймгийн 2018 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний санал авах ажлыг эхлүүлж шинэлэг байдлаар <https://drive.google.com/drive/my-drive> цахим програм ашиглан байгууллагын цахим болон фэйсбүүк хуудсанд санал авах ажлыг 2017 оны 08 дугаар сарын 01-нийг өдрөөс эхэлсэн.

Тус ажлын хүрээнд багийн Засаг дарга, газрын даамал нарт 2 удаагийн мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллалаа. 2018 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нийт 41 байршилд 15 хуулийн этгээд 11 иргэн, Дархан сумын Засаг даргаас 34 байршилд 54 ажил хэрэгжүүлэхээр санал ирүүлснийг хүлээн авч нэгтгээд байна.

## 2.7 Газар эзэмшүүлэх эрхийн газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын талаарх мэдээ, тайлан

2017 онд дуудлага худалдаагаар нийт 477.4 сая төгрөг төвлөрүүлсэн буюу 477%-иар биелүүлсэн. Үүнд:

➤ Дархан сумын хэмжээнд газрын дуудлага худалдааг аймгийн Засаг даргын 2017.04.06-ны өдрийн А/130, 2017.05.16-ны өдрийн А/210, 2017.05.24-ны өдрийн А/230, 2017.07.04-ны өдрийн А/282, 2017.08.09-ны өдрийн А/325, 2017.10.03-ны өдрийн А/387, 2017.10.20-ны өдрийн А/338 дугаар захирамжаар нийт 7 удаа 11 байршилд, төсөл сонгон шалгаруулалтыг аймгийн Засаг даргын 2017.04.06-ны өдрийн А/129, 2017.10.03-ны өдрийн 387 дугаар захирамжаар 2 удаа Дархан сумын Засаг даргын 2017.08.25-ны өдрийн 250 дугаар захирамжаар 1 удаа нийт 34 байршилд зарласан.

Дуудлага худалдаагаар шатахуун түгээх станц, ахуйн хий цэнэглэх станцын зориулалтаар 3 нэгж талбарт 0,71 га газрыг 81,5 сая төгрөгөөр, үйлчилгээний зориулалтаар 2 нэгж талбарт 0,18 га газрыг 323,5 сая төгрөгөөр нийт 0,89 га газрыг 405 сая төгрөгөөр зарж орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.




2017.06.09-ны өдрийн дуудлага худалдаа



2017.06.23-ны өдрийн дуудлага худалдаа

➤ 2017.08.11-нд Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн А/282 дугаар захирамжийн дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 8, 9, 12, 15 дугаар багийн нутаг дэвсгэрт 4-н нэгж талбарт газар эзэмшүүлэх **цахим дуудлага худалдааг анх удаа зохион байгуулсан.**



➤ 2017 оны тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Шарын гол, Орхон сумд газрын дуудлага худалдааг зарлаж зохион байгуулж ажилласангүй.

➤ Хонгор сумын Засаг даргын 2017 оны 33 дугаар захирамжаар 4 байршилд дуудлага худалдаа зарласан боловч оролцогч ирээгүй тул дахин зарлаагүй байна.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

➤ Төсөл сонгон шалгаруулалтын төслийн битүүмжилсэн материалыг 2017.06.06-ны өдөр хүлээн авсан. Нийт 24 төсөл ирсэн байна. Аймгийн Засаг даргын 2017.06.06-ны А/244 дугаар захирамжаар төслийг үнэлж, дүгнэлт гаргах комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж төслийг 2017.06.12-ны өдөр үнэлэх ажил хийгдлээ. Үйлдвэрийн зориулалтаар 4 нэгж талбарт 10,133 га, үйлчилгээний зориулалтаар 4 нэгж талбарт 0,277 га, НОС зориулалтаар 3 нэгж талбарт 0,33 га, спорт цогцолборын зориулалтаар 1 нэгж талбарт 0,18 га, авто зогсоолын зориулалтаар 1 нэгж талбарт 0,9 га, ахмадын сувилалын зориулалтаар 1 нэгж талбарт 0,045 га нийт 14 нэгж талбарт 11,865 га газрыг төсөл сонгон шалгаруулалтаар шалгаруулан эзэмшүүлсэн байна.

➤ Орхон сум 1 удаа 15 байршилд, Хонгор сум 1 удаа 8 байршилд, Шарын гол сум 6 байршилд 1 удаа тус тус төсөл сонгон шалгаруулалт зарлаж, төслийг үнэлэх ажил хийгдсэн бөгөөд Төсөл сонгон шалгаруулалт явуулах журмын хэрэгжилтийг бүрэн хангаагүй байна.



Төсөл сонгон шалгаруулалтаар эзэмшүүлж, ашиглуулсан газрын мэдээлэл

№	Төсөл сонгон шалгаруулалтаар олгосон газрын зориулалт	Нэгж талбарын тоо, ш	Газрын хэмжээ /га/	Газрын байршил	2017 он
					Газар олгосон шийдвэр, он сар өдөр
1	Үйлдвэр	4	10.133	Төмөр замын Дархан гатах хэсгийн зүүн талд, Магнай трейд ХХК агуулахын хойд талд, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК-ны урд талд	Аймгийн Засаг даргын 2017 оны 06-р сарын 27-ны өдрийн А/269
2	Үйлчилгээ	4	0.277	Шинээр хийгдсэн авто замын зүүн талд, 5-р хороолол, Буудай зочид буудлын зүүн талд, Хүслийн хотхоны урд байрлах Магнай трейд ШТС-ын урд	Аймгийн Засаг даргын 2017 оны 06-р сарын 27-ны өдрийн А/269
3	Нийтийн орон сууц	3	0.33	Хуучин хуримын ордоны баруун талд, 24-р хороолол, 13-р хороолол	Аймгийн Засаг даргын 2017 оны 06-р сарын 27-ны өдрийн А/269
4	Спорт цогцолбор	1	0.18	Хуучин хуримын ордоны баруун талд	Аймгийн Засаг даргын 2017 оны 06-р сарын 27-ны өдрийн А/269
5	Авто зогсоол	1	0.9	Улаанбаатар хот явах авто замын дагуу, ТЭС ретропум ШТС-н урд талд	Аймгийн Засаг даргын 2017 оны 06-р сарын 27-ны өдрийн А/269
6	Ахмадын сувилал	1	0.045	Гранд зочид буудлын хойд талд	Аймгийн Засаг даргын 2017 оны 06-р сарын 27-ны өдрийн А/269
	Нийт	14	11.865		



Төсөл сонгон шалгаруулалт явуулсан байдал

Д/д	Төсөл сонгон шалгаруулалт явуулах шийдвэр	Төсөл сонгон шалгаруулалт зарласан нэгж талбарын тоо	Шалгарсан нэгж талбарын тоо
1	Аймгийн Засаг даргын 2017.04.06-ны өдрийн А/129 дугаар захирамж	19	14
2	Дархан сумын Засаг даргын 2017.08.25-ны өдрийн 250 дугаар захирамж	4	0
3	Аймгийн Засаг даргын 2017.10.03-ны өдрийн А/386 дугаар захирамж	11	0
4	Шарын гол сумын Засаг даргын 2017 оны .... сарын ... өдрийн ..... дугаар захирамж	6	3
5	Орхон сумын Засаг даргын 2017 оны 04 сарын 04 өдрийн 12 дугаар захирамж	15	15
6	Хонгор сумын Засаг даргын 2017 оны 02 сарын 15 өдрийн 33 дугаар захирамж	13	13

2017 оны 8-р сарын 06-ны өдөр үргэлжлэн өндөр болсон газруудын орлогогийн бүртгэл

№	Газрын нэр	Газрын төрөл	Газрын төсөв	Газрын төсвийн үйлчилгээний төрөл	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн код	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн нэр	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн код	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн нэр	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн код
1	Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын бүтэц орон тоо шинээр батлагдсантай холбоотойгоор "Инженер хайгуул, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн" ажиллах болсонтой холбогдуулан Дархан-Уул аймгийн Сумдын Засаг нар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний алба, Онцгой байдлын газруудтай хамтран ажиллаж, дараах мэдээллүүдийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэхээр ажиллаж байна. Үүнд:								

2017 оны 8-р сарын 06-ны өдөр үргэлжлэн өндөр болсон газруудын орлогогийн бүртгэл

№	Газрын нэр	Газрын төрөл	Газрын төсөв	Газрын төсвийн үйлчилгээний төрөл	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн код	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн нэр	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн код	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн нэр	Газрын төсвийн үйлчилгээний төрөлийн код
1	Дархан-Уул аймгийн ГХБХБГ-ын бүтэц орон тоо шинээр батлагдсантай холбоотойгоор "Инженер хайгуул, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн" ажиллах болсонтой холбогдуулан Дархан-Уул аймгийн Сумдын Засаг нар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний алба, Онцгой байдлын газруудтай хамтран ажиллаж, дараах мэдээллүүдийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэхээр ажиллаж байна. Үүнд:								

➤ Төсөвт байгууллагын хэрэгцээнд 2017 онд 18 нэгж талбарт 15 га газрыг олгохоор төлөвлөснөөс 23 нэгж талбарт 233,4 га газрыг цэцэрлэг, сургууль, багийн хөгжлийн төв, эрүүл мэндийн үйлчилгээ, аж ахуйн хашаа, хогийн цэг, нийтийн орон сууц, зөөврийн ус түгээх цэг, эрчим хүч дамжуулах станцийн зориулалтаар олгож эзэмшүүлсэн байна.

➤ Нөхөн олговороор олгохоор 3 нэгж талбарт 3,022 га газрыг төлөвлөснөөс 1 нэгж талбарт 1,3 га газрыг олгосон. 2 нэгж талбар нь шүүхийн шатанд маргаантай байгаа тул хэрэгжих боломжгүй болсон байна.

## 2.8 Инженер хайгуул, бэлчээр ашиглалтын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх, мониторингийн цэг байгуулах ажлын тайлан, хянан баталгаа

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2015 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн Б65 тушаалаар тус аймгийн ГХБХБГ-ын бүтэц орон тоо шинээр батлагдсантай холбоотойгоор “Инженер хайгуул, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн” ажиллах болсонтой холбогдуулан Дархан-Уул аймгийн Сумдын Засаг нар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Ус, цаг уур орчны шинжилгээний алба, Онцгой байдлын газруудтай хамтран ажиллаж, дараах мэдээллүүдийг нэгтгэж мэдээллийн сан үүсгэхээр ажиллаж байна. Үүнд:

Дархан-Уул аймгийн хэжээнд ашигт малтмал олборлох болон хайгуулын тусгай зөвшөөрөлтэй нийт 84 аж ахуй нэгж бүртгэгдсэн байна.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017 оны А/16 дугаар Комисс байгуулах тухай ажлын хэсэгт орж Байгаль орчин ногоон хөгжилийн сайдын 2014 оны 05 дугаар тушаал "Журам батлах тухай" дагуу Байгалийн нөөц, баялгийн ашиглалт, нөхөн сэргээлтэд технологийн хяналт тавих, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлгээ дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хурал 2017 оны 01 дүгээр сарын 13, 04 сарын 26-ны өдрүүдийн 2 удаагийн хуралд оролцож нийт 20 аж ахуй нэгж байгууллагын Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, 2017 оны Байгаль орчныг хамгаалах менежментийг төлөвлөгөөг батлахад үнэлэлт дүгнэлт өгч ажилласан.



➤ Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдын төвийн 1:1000 масштабтай байр зүйн зураг, мөн сумдын 1:1000, 1:100 000 масштабтай хаягийн зураг, “Глобус” ХХК-ий хийсэн Дархан сумын сууршлийн бүсийн газрын хянан баталгааны зургуудыг ГЗБГЗЗГ-аас хүлээн авч, зургуудыг сумдын даамлуудад хүлээлгэн өгсөн.

➤ Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017 оны А/18 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг ажлын хэсэг 2017.05.17-2017.06.16-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн ашиглалт, олборлолт явуулж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, эвдэрсэн, нөхөн сэргээлт хийгдээгүй орхигдсон газрын хэмжилт, тооллого явуулан газрын кадастрын мэдээллийн санд бүртгэсэн. Тус ажлыг Аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хонгор сумын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, Хонгор сумын газрын даамал, Шарын гол сумын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч, Шарын голын Цагдаагийн тасагтай хамтран хийж гүйцэтгэсэн. Шалгалтаар Шарын гол суманд 2 газарт зөвшөөрөлгүй алт олборлож байсан иргэдийн техник хэрэгслийг лацдаж үйл ажиллагааг зогсоосон.



Тооллогод Хонгор сумын Могойн зоо, Их ноёны дунд хэсэг, Хүйтний голын хойд ам, Эрэлийн эх, Бичигт хад, Цэхэрийн амны эх, Хавчуу, Шивэрт, Хуурай, Бурхант, Хургадын ам, 4-р бригад, Бух толгой, Цайдам, Хагархай толгой, Шийр уул, Цагаан гозгор, Цохио толгой, Асгат уул, Цогт толгой, Гахайт, Шарын гол сумын Шар хөтөл, Буянтын хөндий, Уурхай орчмын газар нутаг, Орхон сумын Ноёнхонгор, Төмөр замын 96-р зөрлөг, Хар морьтын

даваа, Хүзүү толгой, Дархан сумын Элсэн эрэг, Онгот толгой, Усан сангийн толгой, Хогийн цэгийн урд толгой зэрэг газрууд хамрагдсан.

Аймгийн хэмжээнд нийт 30 нэр бүхий газарт 151 га газрын эвдрэл бүртгэгдсэн. Мөн дээрх ажил хийгдсэнээс хойш хугацаанд аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газраас хууль бусаар ашигт малтмал олборлосон иргэн, хуулийн этгээдийн 20 хэмжилтийг ирүүлж 73106 м2 талбайн хэмжээг тодорхойлж өгсөн.

Цаашид орон нутгийн болон улсын төсөвт тодорхой хөрөнгийг суулгаж шат дараатай арга хэмжээ авах шаардлагатай байна.

Аймгийн хэмжээнд 12 цэг сонгон авч Орхон сум 10 цэг, Шарын гол сум 2 цэгт фото мониторинг хийж тайланг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

➤ Дархан-Уул аймгийн хэмжээнд “Хот тосгон, суурин газрын төлөв байдлын чанарын хянан баталгаа”-г 2015 онд Глобус ХХК гүйцэтгэсэн бөгөөд тайланг ГЗБГЗЗГ-аас 2017.06.08-ны өдөр хүлээж авсан. 2017 онд “Дархан-Ус суваг” ХК, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК, “НИК” ХХК, “Дархан Дулааны цахилгаан станц” ТӨХК, “Шарын гол” ХХК-ий нийт 2148,57 га талбайд захиалгат хянан баталгааг 25 нэгж талбарт хийлгэсэн байна.

Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулдаг хянан баталгаа хийх тусгай зөвшөөрөл бүхий “Эхлэх цэг хангай” ХХК-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулан ажиллаж байна

➤ Байгууллагын 2017 оны сургалтын төлөвлөгөөний дагуу Фото мониторингийн аргаар бэлчээрийн ургац, даац шинж чанарыг тодорхойлох, Sample point програм хангамжид тооцоолох арга аргачлалд Хонгор сумын даамал Н.Мөнхцэцэг, Орхон сумын даамал М.Халиун нарыг сургалтад хамруулсан.



ХААИС-ийн арын талбайд дадлага хийсэн /2017.06.08/

➤ Мөн Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Швейцарын хөгжлийн агентлаг "Ногоон-Алт малын эрүүл мэнд төсөлтэй хамтран "Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх, мэдээлэл боловсруулах тайлан гаргах" сэдэвт сургалтыг 2017 оны 7 дугаар сарын 3-4-ны өдрүүдэд Дархан-Уул аймгийн Залуучуудын хөгжлийн төвийн сургалтын танхимд зохион байгууллаа.

Сургалтанд Дархан-Уул, Сэлэнгэ аймгийн ГХБХБГ-ын Инженер хайгуул, мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон сумдын /Дархан-Уул аймгийн 3, Сэлэнгэ аймгийн 17-н сумын газрын даамлууд/ газрын даамлууд хамрагдлаа.

Сургалтаар бэлчээрийн ургамлыг аж ахуйн бүлгийн түвшинд таних чадварыг эзэмшүүлэх, фото мониторингийн мэдээг боловсруулалтын чанарыг сайжруулан улмаар бэлчээрийн төлөв байдал өөрчлөлтийн загвар ашиглан үнэлгээ, үр дүнг тайлагнах чадвар эзэмшүүлэх зэрэг сэдвүүдээр сургалтыг зохион байгуулсан ба Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутагт хээрийн дадлагын ажлыг хийсэн.



## 2.9 Газар өмчлөлийн мэдээ, тайлан

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 17 дугаар тогтоолоор 2017 онд Дархан-Уул аймагт иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын саналыг ГЗБГЗЗГ-т хүргүүлж, Засгийн газрын 2017 оны 104 дүгээр тогтоолоор:

- Шинээр 666 иргэнд 85,41 га газар,
- Хуучин хашааны газарт 303 иргэнд 45,93 га газрыг өмчлүүлэхээр батлагдсан.

2017.12.15-ны өдрийн байдлаар 352 иргэнд 30,02 га газрыг өмчлүүлж, 36,5 хувьтай байна.

сумын нэр	Төлөвлөсөн		Хэрэгжилт		Хувь	
	Шинээр	Хуучин сууршлийн бүсэд	Шинээр	Хуучин сууршлийн бүсэд	Иргэн	га

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

	Иргэний тоо	Талбайн хэмжээ /га-аар/	Иргэний тоо	Талбайн хэмжээ /га-аар/	Иргэний тоо	Талбайн хэмжээ /га-аар/	Иргэний тоо	Талбайн хэмжээ /га-аар/		
<b>Дархан сум</b>			240	17.43			98	6.8	40.80%	39%
<b>Шарын гол сум</b>	31	2.17	63	30.67	31	2.17	62	1.822	98,9%	12.15 %
<b>Хонгор сум</b>	525	75.24			37	5.3			7.10%	7.10%
<b>Орхон сум</b>	110	8			186	13.8984			169%	173.73%
<b>Нийт</b>	<b>666</b>	<b>85.41</b>	<b>303</b>	<b>48.1</b>	<b>223</b>	<b>19.1984</b>	<b>98</b>	<b>6.8</b>	<b>78.94%</b>	<b>57.9 %</b>

➤ Хамтран өмчлөх эрхээсээ татгалзаж, шинээр газар өмчлөх эрхээ сэргээлгэхийг хүссэн 208 иргэний хүсэлтийг хүлээн авч Дархан сумын Засаг даргын 11 удаагийн захирамжаар шийдвэр гарган ажиллалаа.

➤ Дархан-Уул аймгийн хэмжээнд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжсэнээс хойш газрын судалгааг гаргаж, Дархан, Хонгор, Орхон, Шарын гол сумдад газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэх, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцүүлэг зохион байгуулсан.

➤ Дархан-Уул аймгийн иргэдийн газар өмчлөлийн мэдээлэл, сум тус бүрээр:

№	Сумын нэр	2003-2008 он					
		Шинээр олгосон		Хуучин хашааны газар		Нийт дүн	
		Иргэний тоо	Талбайн хэмжээ га	Иргэний тоо	Талбайн хэмжээ га	Иргэний тоо	Талбайн хэмжээ га
1	Дархан	818	57.26	3531	375.73	4349	432.99
2	Хонгор	105	7.35	1013	117.890691	1118	125.240691
3	Орхон	-	-	579	142.69515	579	142.69515
4	Шарын гол	-	-	427	45.25665	427	45.25665
5	Аймгийн дүн	923	64.61	5550	681.572491	6473	746.182491

№	Сумын нэр	2009-2017 он						
		Шинээр олгосон		Хуучин хашааны газар		Нийт дүн		Газар өмчлөлийн хувь
		Иргэний тоо	Талбайн хэмжээ га	Иргэний тоо	Талбайн хэмжээ га	Иргэний тоо	Талбайн хэмжээ га	
1	Дархан	2126	148.82	2327	212.64	4453	361.46	<b>10.70 %</b>
2	Хонгор	366	25.62	222	141.20926	588	166.82926	<b>27.59 %</b>
3	Орхон	1333	93.31	249	43.92543	1582	137.23543	<b>67.83 %</b>
4	Шарын гол	86	6.02	335	33.09155	421	39.11155	<b>10.37 %</b>
5	Аймгийн дүн	3911	273.77	3133	430.86624	7044	704.63624	

6	2003-2017 оны аймгийн дүн	4834	338.38	8683	1112.438731	13517	1450.08	13.54 %
---	---------------------------------	------	--------	------	-------------	-------	---------	---------

Судалгаанаас харахад аймгийн хэмжээнд газар өмчлөл 13.54%, Орхон суманд хамгийн өндөр буюу 67.83%, Хонгор сум 27.59 %, Дархан сум 10.70 %, Шарын гол сум 10.3% байна.

Энэ нь төдийлөн хангалттай сайн үзүүлэлт биш юм. Иймээс хууль хэрэгжиж дуусах хугацаанаас өмнө, аймгийн бүх сумдын хуучин хашаатай иргэний газрыг үнэ төлбөргүй өмчлүүлж дуусах зайлшгүй шаардлагатай байна.

Сумдын даамлууд тухайн сумынхаа иргэний тоо, шилжилт хөдөлгөөн, хуучин хашаатай айл өрхийн судалгааг дахин нягтлан шалгаж, өмчлөлийн талаарх бодит тоо мэдээллийг шинэчлэн тогтоож одоо газраа өмчлөөгүй байгаа хуучин хашааны газартай айл өрхийг 2018 оны тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулж, өмчлүүлэх ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

➤ Газар өмчлөх эрхээ бусад аймаг, орон нутагт хэрэгжүүлэхээр хүсэлт гаргасан 516 иргэнд лавлагаагаар үйлчилсэн байна. Газар өмчлөлийн мэдээг аймгийн хэмжээнд нэгтгэн ГЗБГЗЗГ-т улирал тутам хүргүүлэн ажиллалаа.

➤ Газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлж, цаашид авах арга хэмжээний талаар

Монгол Улсын иргэнд үнэ төлбөргүй газар өмчлүүлэх хуулийн хэрэгжих хугацаа дуусах дөхөж байгаатай холбогдуулан Дархан-Уул аймгийн хэмжээнд газар өмчлүүлэх ажлыг эрчимжүүлэн, иргэдийн идэвхи, оролцоог хангаж, иргэн бүрт үнэ төлбөргүй газар өмчлүүлэх төрийн бодлогыг бүрэн хэрэгжүүлэх, 2018 оны 05-р сараас өмнө Дархан-Уул аймгийн сумдын нутаг дэвсгэрт, хуучин хашааны газартай иргэдийн эзэмшилд байгаа газрыг иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан бүрэн өмчлүүлж дуусгах зорилт тавьж байна.

Иргэдэд газрыг үнэ төлбөргүй нэг удаа өмчлүүлэх тухай, хуулийн хэрэгжих хугацаа дуусах дөхөж байгааг сурталчлан ойлгуулж, энэ ажилд аймгийн ГХБХБГ, сумдын даамлуудаас гадна, багийн Засаг дарга, Нийгмийн ажилтнуудыг өргөн хүрээтэй оролцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Аймгийн хэмжээнд газар өмчлөлийн хувь маш бага байгааг анхаарч үзэн, иргэний газраа үнэ төлбөргүй өмчлөх эрхийг хангах талаар дараах боломжуудыг судалж шийдвэрлэх нь зүйтэй байна. Үүнд:

### **Боломж нэг**

Дархан сумын нутаг дэвсгэрт байгаа хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийгдсэн, амины орон сууцны хорооллуудын газрыг иргэдийн саналд тулгуурлан өмчлүүлэх

/ X, ХХҮ, II, XIII хороолол /

**Боломж хоёр**

Дархан-уул аймгийн амралт, зуслангийн бүс болох “Зулзагын голын” зуслангийн газруудыг иргэдэд өмчлүүлэх

**Боломж гурав**

Газраа өмчлөөгүй байгаа иргэдийн хуучин эзэмшиж байгаа хашааны газрыг бүрэн өмчлүүлэх

Шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Дархан, Орхон, Хонгор, Шарын гол сумын холбогдох мэргэжлийн байгууллага, ажилтнууд, аймгийн Ерөнхий архитектороос тодорхой санал авч саналыг нэгтгэн хэрэгжүүлж ажиллах юм.

- Газрыг хамгаалах, нөхөн сэргээх сан байгуулах, сангийн журам боловсруулах

Дархан-Уул аймгийн хэмжээнд газрыг хамгаалах, нөхөн сэргээх, газрын харилцаатай холбоотой тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. Иймээс газрыг хамгаалах, нөхөн сэргээх санг байгуулж, санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээг гаргах, арга хэмжээг зохион байгуулж энэхүү журмыг боловсруулсан. Газрын төлбөрөөс орж буй орлогын тодорхой хувь, газар эзэмших эрхийн гэрчилгээг сунгуулах, газар эзэмших эрх шилжүүлэх үйлчилгээний хураамжийг хуульд заасны дагуу төвлөрүүлэх, Газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй холбоотой зардлын асуудлууд, Иргэнд анх удаа өмчлүүлж буй төрийн мэдлийн газрын, Газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгаа хийлгэх зэрэг олон асуудлууд шийдвэрлэгдэнэ гэж үзэж байна.



- Газар ашиглалтыг сайжруулах, гэрээний биелэлтийг хангах, талаар



Дархан сумын нутаг дэвсгэрт газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газар ашиглалт маш муу, зарим газар эзэмшигч, ашиглагч удаа дараа газар эзэмших гэрээний хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сунгуулдаг, иймээс газрын



ашиглалт муу байгаа нь хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын үйл ажиллагаанд муугаар нөлөөлж, сөрөг үр дагавар авчирч байна. Иймээс Газар эзэмших ашиглах гэрээ дүгнэх журмыг ГХБХБГ-ын даргын 2017.09.07 №А/30 дугаар тушаалаар баталж, энэ байдалд бодит дүгнэлт хийж, газрын ашиглалтыг сайжруулах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.

Газар эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын гэрээ хийсэн эзэмшигчтэй шинээр **“Харилцан ойлголцлын санамж бичиг”** байгуулж, Газар ашиглалтын төлөвлөгөөг гаргуулан авч байна.

Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулж, Газар ашиглалтын төлөвлөгөө гаргуулахаар нийт 64 газар эзэмшигчтэй ярилцаж, 21 аж ахуйн нэгж, 43 иргэн хамрагдаж Газар ашиглалтын төлөвлөгөө гаргаж өгсөн 21 санамж бичиг байгуулсан боловч төлөвлөгөө ирүүлээгүй 37 газар байна.



➢ Газар өмчлөлтэй холбоотой гарч буй газрын зөрчил маргааны ихэнх хувь нь өмчлөлийн газраасаа илүү гаргаж хашаагаа сунгах, бусдын өмчлөлийн газарт дураараа сунгалт хийх, орц гарц хаасан зэрэг шалтгаантай байна. 2017 онд эзэмшил, өмчлөлийн газраасаа илүү гаргаж хашаагаа сунгасан 13 иргэн, хуулийн этгээдийн газарт шаардах хуудас хүргүүлж 10 зөрчлийг арилгасан. Орц гарц хаасан 1 иргэний гомдлын дагуу хяналтын хэмжилтийг хийж орц гарцыг тодруулсан байна. Эрх бүхий байгууллагын зохих

зөвшөөрөлгүй дураараа хашаа барьсан, төмөр замын ажил эхлүүлсэн 1 хуулийн этгээдэд газар чөлөөлөх хугацаатай мэдэгдэх хуудсыг хүргүүлж арга хэмжээ авч ажиллалаа.

## 2.10 Газрын зөрчил, маргаан түүнийг шийдвэрлэсэн байдал

➤ 2017 оны тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд зөвшөөрөлгүй хашаа, барилга барьсан 60 иргэн, хуулийн этгээдийг буулгах нүүлгэн шилжүүлж, газар чөлөөлөх арга хэмжээ авахаар тусгасан боловч хөрөнгө санхүүгийн асуудал шийдэгдээгүй тул хэрэгжээгүй.



➤ “Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ” ТӨХК-ий болон “Дархан сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ий инженерийн шугам сүжээний хамгаалалтын зурваст байрлаж буй айл өрх, барилга объектын судалгааг гаргасан. Үүний дагуу Дархан сумын 1 дүгээр баг Чулуутын гудамжаар дайран өнгөрөх ЦДҮСүлжээ ТӨХК-ий 110 кВ-н Дархан агаарын шугамын хамгаалалтын зурваст орсон нийт **36** айл өрхийн судалгааг гаргаж чөлөөлөгдөх талбайн хэмжээг тооцон, нөхөн олговорын **50 382 900** төгрөгийг төсвийн тодотголоор оруулж хэлэлцүүлэн шийдвэрлэж өгөхийг хүссэн албан бичгийг Хөгжлийн бодлогын хэлтэс хүргүүлсэн. Нөхөн олговорыг Засгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэнд өмчлүүлэх газрын үнэлгээний аргачлал”-ыг үндэслэн 1м<sup>2</sup> газарт олгогдох нөхөн олговорын үнэлгээгээр тооцсон.

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



**Исхэнэрийн шугам сүсэний хамгаалалтын зурваст байрлаж буй өрхийн судалгаа**

АШ	Байршил	Ургам, өм зориулалт	Хүйс	Газрын эзэмшилтийн төрөл	Хамгаалалтын зурваст орсон өрхийн тоо	Нэгжүүд
101	...	...	...	...	...	...
102	...	...	...	...	...	...
103	...	...	...	...	...	...
104	...	...	...	...	...	...
105	...	...	...	...	...	...
106	...	...	...	...	...	...
107	...	...	...	...	...	...
108	...	...	...	...	...	...
109	...	...	...	...	...	...
110	...	...	...	...	...	...

№	АШ	Байршил	Ургам, өм зориулалт	Хүйс	Газрын эзэмшилтийн төрөл	Хамгаалалтын зурваст орсон өрхийн тоо	Нэгжүүд
1	101	...	...	...	...	...	...
2	102	...	...	...	...	...	...
3	103	...	...	...	...	...	...
4	104	...	...	...	...	...	...
5	105	...	...	...	...	...	...
6	106	...	...	...	...	...	...
7	107	...	...	...	...	...	...
8	108	...	...	...	...	...	...
9	109	...	...	...	...	...	...
10	110	...	...	...	...	...	...

Энгийн газрын 2003 оны 103 дугаар тогтоолоор Белградан "Иргэнд амьжиргаа газрын үндэслэлийг өргөснөө" –ий үндэслэл тэг газарт олгогдох –нөм- олгоогийн үндэслэл тооцов.

Мөн ДСЦТСүлжээ ТӨХК-ий 6 кв-ын шугамын хамгаалалтын бүсэд орсон 7-р баг Майхантын 5, 6, 7-р гудамжны 8 өрх, 15-р баг 9-р хэсэгт 9 өрх, 15-р баг 10-р хэсэгт 6 өрх нийт **23** өрхийн судалгааг гаргаж хуулийн дагуу шийдвэрлүүлэхээр ажиллаж байна.

➤ Аймгийн Засаг даргын 2016 оны Аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ны өдрийн А/437, А/438, А/440, А/441, А/442, А/443, А/497 дугаар захирамжаар газар эзэмших эрхийн гэрчилгээ, өмчлөх эрх нь хүчингүй болсон 74 иргэн, 22 хуулийн этгээд Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасны дагуу нийт 96 шүүхийн тайлбар бичиж, 14 удаагийн шүүх хуралд оролцсон.


Үүнээс шийдвэрлэгдсэн байдал:

№	Шийдвэрлэгдсэн байдал	Тоо хэмжээ
1	Хариуцагчийн зөвшөөрлийг баталж	63
2	Шүүхийн шийдвэрээр нэхэмжлэлийн шаардлагыг хангасан	30
3	Шүүгчийн захирамжаар хэргийг хэрэсэхгүй болгосон	3
4	Зөвшөөрөлгүй газраа сунгасан зөрчлийг арилгуулсан	4
5	Зөрчил арилгах, сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлсэн	6
<b>НИЙТ</b>		106

Дээрх газрын зөрчил маргаан яагаад гарах болсон талаар дэлгэрэнгүй тайлбарыг  
ГЗБГЗЗГ-т 2017.11.28-ны өдрийн 978 тоот албан бичгээр хүргүүлсэн.



*14-р баг, 2-р хороолол, У.Ирээдүй 2 айлын гарц хааж блокон хашаа  
барьсныг буулгуулсан /2017.05.15/*



*13-р баг, Их сургуулийн 6-1 тоотын зүүн талд Сүхбаатарын 2м сунгасан модон хашааг буулгасан  
/2017.05.12/*



*13-р баг, Баярхүүгийн зөвшөөрөлгүй барьсан гараж дээр ГТХ-ийн 33.1.2-т нийцүүлэн зөрчлийг  
арилгуулсан.*



*13-р баг, Өмнөд үйлдвэрийн районд, “Дархан-Дуулга” ХХК-ний эзэмшил газартай давхцуулж “Эрин тарвагатай” ХХК-нь эзэмшил газраасаа илүү гаргаж блокон хашаа барьсан, мөн “Дархан төмөрлөг” ТӨХК зохих зөвшөөрөлгүйгээр терминал байгуулан, зам талбай гаргасан тул хяналтын хэмжилт хийж, зөрчил арилгах албан тоот хүргүүлсэн.*

Газрын маргаан шүүхээр шийдвэрлэгдэх болсон шалтгаан:

- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 173 дугаар тогтоол “Монгол Улсын иргэнд 2016 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтыг тогтоох тухай”-ыг зөрчиж газар өмчлүүлсэн.
- Газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-т хүсэлт гаргасан газар нь бусдын эзэмшиж, ашиглаж байгаа газартай давхцуулж газар олголт хийсэн.
- 2016 оны 32 дугаар тогтоолоор батлагдсан Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй газарт газар олгосон.
- Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтгүй олгосон
- Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмыг зөрчсөн


#### **2.11 Газрын төлбөр, татварын мэдээ, тайлан**

2017 онд газрын төлбөрийн орлогоос 652,0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээс 664.7 сая төгрөгийг төвлөрүүлж, газрынтөлбөрийн гүйцэтгэл 102 хувиар биелэлээ.

2017 оны 11-р сарын 30-ны өдрийг дуустал газрын төлбөрийн гүйцэтгэлийг сум тус бүрээр үзүүлбэл:

Сумын нэр	2017.01.01-2017.11.30		
	Жилээр	1-11 сар	Биелэлт
Шарын гол	58,000,000.00	51,231,336.43	88.33
Хонгор	205,000,000.00	97,192,684.27	47.41
Орхон	39,000,000.00	41,632,452.00	106.75
Дархан	350,000,000.00	385,671,434.38	110.19
<b>НИЙТ</b>	<b>652,000,000.00</b>	<b>575,727,907.08</b>	<b>88.30</b>

/12-р сарын хуулга боловсруулалт дараа сарын 05-ны өдөр хийгдэх тул 11-р сарын байдлаар үзүүлэв/  
Газрын төлбөрийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг сүүлийн 7 жилийн байдлаар үзүүлбэл:





Дээрх байдлаас харахад 2015, 2016 онуудад газрын төлбөрийн орлого 116.3 сая төгрөгөөр тасалдаж байсан бол 2017 онд 100 хувь биелэсэн байна.

**Газрын төлбөрийг барагдуулах ажлын талаар авч хэрэгжүүлсэн ажил:**

1. 2017 онд газрын төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу Зөвлөгөөнийг 2017.03.29-ны өдөр ГХБХБГ-ын хурлын танхимд зохион байгуулсан.



2. Зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн дагуу аймгийн Татварын хэлтэс, газрын даамлууд хамтран Хонгор, Шарын гол суманд 2017.04.-10-2017.04.15-ны хооронд ажиллаж, газрын төлбөрийн ногдуулалтыг гэрээгээр зөв тогтоосон эсэхийг шалгаж, дүгнэлт гаргасан.



3. Шалгалтын үр дүнгээр нийт 5067 гэрээнээс 661.9 сая төгрөгийг жилд төвлөрүүлэхээр байна. Иймд гэрээгээр ногдуулсан жилийн төлбөрийн ногдлоор тухайн газар эзэмшигч, ашиглагч нэг бүрээр захирамж гарсан өдрөөс хойш тооцож, газрын төлбөрийг төлж байсан эсэхэд хяналтыг тавьж, өмнөх оны илүү дутуу үлдэгдлийг гаргахаар аймгийн Татварын хэлтэст 2017.05.16-ны өдрийн 374 тоот албан бичгээр болон [Darkhan@mta.gov.mn](mailto:Darkhan@mta.gov.mn) цахим хаягаар хүргүүлсэн. Үүнд:

Шарын гол сум	417 гэрээнээс 68.8 сая төг
Хонгор сум	1237 гэрээнээс 184.3 сая төг
Дархан сум	546 ААНБ-аас 316.8 сая төг
	592 иргэн 78.8 сая төг
	1295 ины орон сууц 6.7 сая төг
	1295 гараж 6.5 сая төг

4. Газрын төлбөрийн орлогыг бүрэн төвлөрүүлэх, тасалдаж байгаа орлогын хэмжээг нэмэгдүүлэх, газар эзэмших, ашиглах гэрээг дүгнүүлэх зорилгоор “Мобиком корпораци”-тай хамтран “МОБАЙЛ СУРТАЛЧИЛГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭ”-г явуулахаар 2017.05.30-ны өдөр 4100 газрын гэрээтэй ИААНБ-д хүргүүлэхээр судалгаа гарган Мобикомийн [ulamundrakh.kh@mobicom.mn](mailto:ulamundrakh.kh@mobicom.mn) цахим хаягаар хүргүүлж, 2017.08.30-ны өдөр аймгийн

хэмжээнд газрын төлбөр төлж, гэрээг дүгнүүлэх текстэн зарыг газрын гэрээнд бүртгэлтэй 4065 мобикомын хэрэглэгчдэд хүргүүлсэн.

5. Газрын төлбөрийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу жил бүр газрын төлбөрийн хувь хэмжээ нь биелэдэггүй Хонгор суманд 2017.10.16-20-ны өдрүүдэд томилолтоор ажилласан.

Ажиллах хугацаандаа 27-н ААНБ-ын 117 нэгж талбарт 83.4 сая төгрөгийг барагдуулахаар газрын төлбөрийн тооцоо нийлж, сумын Засаг даргын 2017.10.18-ны өдрийн 1/1037 тоот албан бичгээр газрын төлбөр барагдуулахыг мэдэгдсэн. 2017.12.01-ны өдрийн байдлаар 10-н ААНБ-ын 33.1 сая төгрөгийг барагдуулсан байна. Үүнд:

➤ “Дархан гурил тэжээл” ХХК-аас 1999-2015 оны газрын төлбөрийн өр болох 17,8 сая төгрөгийг шүүхийн шийдвэрийн дагуу албадан гаргуулахаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албатай гэрээ байгуулсан ажиллаж, 2017.11.30-ны өдөр 16.6 сая төгрөгийг бүрэн барагдуулсан. Мөн 2016, 2017 оны 10.6 сая төгрөгийг барагдуулах хугацаатай албан мэдэгдлийг тус байгууллагад хүргүүлснээр 2017.11.24-ны өдөр 6.1 сая төгрөгийг барагдуулсан байна.

➤ “Агч трейд” ХХК-ний 2012-2015 оны 27.3 сая төгрөгийн шүүхийн шийдвэртэй, 2016-2017 оны 13.6 сая төгрөг нийт 41.0 сая төгрөгийн газрын төлбөрийн өрийг барагдуулахаар аймгийн Татварын хэлтэст албан тоот хүргүүлэн хамтран ажиллаж байна.

➤ “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-тай 2003-2017 оныг дуустал 51.8 сая төгрөгийн тооцоо нийлж үүнээс 5.0 сая төгрөгийг барагдуулсан ба үлдэгдэл 46.8 сая төгрөгийг барагдуулах тал дээр мөн аймгийн Татварын хэлтэстэй хамтран ажилласнаар 2017.11.28-ны өдөр 10.0 сая төгрөгийг барагдуулаад байна.

➤ “Дархан таван нуур” ХХК-тай 2017 онд төлөх 13.6 сая төгрөгийн газрын төлбөрийн тооцоо нийлж хугацаатай мэдэгдэл хүргүүлсэн.

➤ Шинэ орчин трейд ХХК-тай 2017 онд төлөх 6.5 сая төгрөгийн газрын төлбөрийн тооцоо нийлж хугацаатай мэдэгдэл хүргүүлсэн.

➤ “Маргац цэцэн уул” ХХК-ний газар эзэмших эрх дуусгавар болсонтой холбогдуулан газар эзэмших эрхийн гэрчилгээний хүчин төгөлдөр байх хугацааны буюу 2015 оны 601 650 төгрөгийг нөхөн төлүүлэхээр хугацаатай сонгох ажиллагааны мэдэгдэл хүргүүлсэн.

6. Газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт 107, Хонгор суманд 27, нэхэмжлэлээр 36, бусад /гараж, амины орон сууц/ хэлбэрээр 28 нийт 198 газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт үйлдсэн байна.

➤ 2017 оны 11 сарын 23, 24-ны өдрүүдэд ГЗБГЗЗГ-ын Кадастрын хэлтсээс газрын төлбөр, татвар, үнэлгээ хариуцсан мэргэжилтнүүдтэй цахим видео хуралд оролцож, газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын



1997 оны 152 тогтоолоор батлагдсан газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулсан “Газрын үнэлгээний зэрэглэл /бүс/, 1га газрын суурь үнэлгээ, төлбөрийн хувь, хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд Дархан-Уул аймгийн 1га газрын суурь үнийг газрын зах зээлийн үнийн мэдээний судалгаан дээр үндэслэн 400.0 сая байхаар саналыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 2017.11.27-ны өдрийн 967 тоот албан бичгээр хүргүүлсэн.




## 2.12 Газрын цахим биржийн мэдээ, тайлан

➤ 2017 онд цахимаар анх удаа 4 нэгж талбарыг дуудаж 1 нэгж талбар буюу 0,06 га газрыг 20 сая төгрөгөөр худалдсан.

➤ Газрын төлбөрийн хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 152 тогтоолоор батлагдсан газрын суурь үнэлгээг шинэчлэн боловсруулсан “Газрын үнэлгээний зэрэглэл /бүс/, 1га газрын суурь үнэлгээ, төлбөрийн хувь, хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд Дархан-Уул аймгийн 1га газрын суурь үнийг газрын зах зээлийн үнийн мэдээний судалгаан дээр үндэслэн 400.0 сая байхаар саналыг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт 2017.11.27-ны өдрийн 967 тоот албан бичгээр хүргүүлсэн.

➤ Газрын цахим биржийн програмд төсөл сонгон шалгаруулалтыг бүртгэхэд эрхийн төрөл нь автоматаар өмчлөх хэлбэрээр гарч байгаа тул Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоол “Газар эзэмшүүлэх, ашиглуулах төсөл сонгон шалгаруулах журам”-ын 2 дугаар хавсралттай зөрчилдөж байгаа тул эрхийн төрлийг эзэмших, ашиглах сонголтой болгох саналыг хүргүүлсэн.



Мөн ГЗБГЗЗГ-аас газрын биржийн вэб хандалтат програм хангамж хөгжүүлэх 2017/25 тоот гэрээт ажлын <http://202.21.125.17> хаяг дээр газрын биржийн програм хангамжийн туршилтын хувилбарыг модуль тус бүрээр нь хэрэглэгчдийн болон удирдлагын түвшинд шалгаж, туршилтын ажлыг гүйцэтгэж гарсан үр дүн болон холбогдох саналаа 2017.11.07-ны өдрийн 865 тоот албан бичгээр хүргүүлсэн.

### 2.13 Газрын харилцааны чиглэлээр хяналт шалгалт хийсэн ажлын тайлан

➤ Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний баг 2017 онд хийх “Гүйцэтгэл сайжруулах” ажлын төлөвлөгөө гарган газрын даргаар 2017.01.16-ны өдөр батлуулсан.

Төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил:

1. Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтод 2017.03.27-ны өдөр хяналт шинжилгээ үнэлгээ хийж, дүгнэлт гаргаж танилцуулсан. Шалгалтын үр дүнд Газрын удирдлагын хэлтсийн ажил 56,7 хувьтай, албан хэрэг хөтлөлт 79.9 хувь, санхүү 85.7 хувийн үнэлгээ тус тус авсан.


Дахин шалгалтыг 2017.06.20-ны өдөр хийж нийт хувь хэмжээ 62.6 хувьтай байсан бол **дахин шалгалтаар** 82.1 хувьтай болсон байна. Шалгалтын дүнг өмнөх хийсэн шалгалтын дүнтэй харьцуулахад дунджаар 19.5 хувиар албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод өссөн үзүүлэлт гарсан.

Ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлын өссөн хувийг хүснэгтээр үзүүлбэл:

№	Ажлын байрны тодорхойлолт	Тасалдсан ажил	Өмнө авсан оноо	Дахин шалгалтын дүн	Хүрсэн түвшин	Өмнөх алдсан оноо	Өссөн хувь
1	Газрын удирдлагын хэлтсийн дарга	3	54.4	70	86.3	45.6	31.9
2	Мэдээллийн сан, техник, програм хангамж	5	75.9	50	88.0	24.1	12.1
3	Геодези зураг зүй	4	77.8	60	91.1	22.2	13.3
4	Архив, бичиг хэрэг	8	79.9	71	94.2	20.1	14.3
5	Кадастр	6	48.2	50	74.1	51.8	25.9
6	Газрын төлбөр	5	80	50	90.0	20	10.0
7	Газар өмчлөл	13	46.9	56	76.6	53.1	29.7
8	Инженер хайгуул, мониторинг	13	14.2	31	40.8	85.8	26.6
9	Нягтлан	7	85.7	82.6	97.5	14.3	11.8
		<b>64</b>	<b>62.6</b>	<b>57.8</b>	<b>82.1</b>	<b>37.4</b>	<b>19.5</b>

2. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтээр шалгалтыг хийж, үр дүнг аймгийн Хяналт шинжилгээ, үнэлгээ Дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн. Шалгалтаар 86.4 хувьтай үнэлэгдсэн ба 2016 оны /71,3хувь/ үнэлгээний дүнтэй харицуулахад 15.1 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан.

3. Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын даргын 2016 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан “Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, Газрын даамлын ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүрэг бүрэн хэрэгжиж байгаа эсэх, 2017 оны 03-р сарын 29-ны өдрийн зөвлөгөөнөөс гарсан сумдын Засаг дарга, газрын даамлуудыг мэргэжил арга зүйгээр хангах зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шалгалтыг удирдамжид зааснаар 2017.05.31-2017.06.02-ны өдрүүдэд Орхон, Хонгор, Шарын гол сумдад байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний багийн ажлын хэсэг ажилласан.



Сум тус бүрээр шалгалтын үр дүнг хүснэгтээр үзүүлбэл:

№	Сумын нэр	Шалгуур үзүүлэлт		Бодит гүйцэтгэл /хувь/	Ажлын байрны тодорхойлолт		Бодит гүйцэтгэл /хувь/
		Авах ёстой оноо	Авсан оноо		Авах ёстой оноо	Авсан оноо	
1	Шарын гол	700	516.8	73.8	100	71.8	
2	Орхон	700	351.9	50.2	100	55	
3	Хонгор	700	201.8	28.8	100	29.1	
<b>НИЙТ</b>		<b>2100</b>	<b>1070.5</b>	<b>50.9</b>	<b>300</b>	<b>155.9</b>	<b>51.9</b>

**Сум тус бүрээр нийт 7 шалгуур үзүүлэлтээр шалгасан үнэлгээг үзүүлбэл:**

№	Сумын нэр	Геозеийн хэмжилт зураглал, цэг тэмдэгтийн бүртгэл, хамгаалалтын явц /100 оноо/	Инженер хайгуул, мониторингийн ажлын хэрэгжилт /100 оноо/	Газар зохион байгуулалтын төлөвлөлт, хэрэгжилт /100 оноо/	Кадастрын ажлын явц /100 оноо/	Орон зайн мэдээлэл, технологийн ажлын явц /100 оноо/	Дотоод ажлын явц /100 оноо/	Мэдээллийн хадгалалт, хамгаалалт /100 оноо/	НИЙТ АВСАН ОНОО	Боди гүйцэтгэл /хувь/
1	Шарын гол	86	53	80.2	62	78.6	71.4	85.6	516.8	73.8
2	Орхон	50.6	42.8	70	20.2	66	52.3	50	351.9	50.2
3	Хонгор	39.4	18	21	20	55.8	23	24.6	201.8	28.8
<b>НИЙТ</b>		<b>176</b>	<b>113.8</b>	<b>171.2</b>	<b>102.2</b>	<b>200.4</b>	<b>146.7</b>	<b>160.2</b>	<b>1070.5</b>	<b>50.9</b>

Шалгалтын үр дүнгээс харахад Шарын гол сумын газрын даамлын ажлын ажил үүрэг, газрын харилцааны чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээ нь жигд хэвийн явагдаж байна.

Хонгор сумын хувьд маш хангалтгүй үзүүлэлттэй бол Орхон сумын хувьд ажил үйлчилгээ нь 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

**Нийтлэг гарсан алдаа дутагдал, зөрчлийн хувьд:**

1. Инженер хайгуул мониторингийн ажлын хэрэгжилт хангалтгүй /хянан баталгааны ажлууд, бэлчээрийн фото мониторингийн ажил/
2. Газрын кадастрын мэдээллийн сангийн хөтлөлт /жижүүрийн зураг, нэгж талбарын хувийн хэрэг, улсын бүртгэлийн дэвтрийн хөтлөлт, архивын хадгалалт хамгаалалт/ хангалтгүй
3. Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй /хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт гараагүй, судалгаа дүгнэлт байхгүй/, газрыг дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгодоггүй, Газрын тухай хууль зөрчсөн
4. Хаягжуулалтын ажил удаашралттай

5. Цахим биржийн хэрэглээ байхгүй /www.mle.mn-д үнийн мэдээ, барьцааны бүртгэл байхгүй, дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтын зар мэдээ оруулаагүй, цахимаар зохион байгуулаагүй байна/

6. Газрын кадастрын мэдээллийн сангийн “Лэнд менежер” програм хангамжийн хэрэглээ хангалтгүй

7. Геодезийн цэг тэмдэгтийн судалгаа хангалтгүй /устсан, тоолсон, гэм буруутай этгээдийг олж тогтоосон, сэргээн босгох талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ аваагүй/

8. Хонгор, Орхон сум хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөгүй

9. Хонгор, Шарын гол, Орхон сумууд газрын төлбөрийн хэмжээг тогтоосон сумын ИТХ-ын тогтоолыг ГНС-ийн ангилалын дагуу шинэчлэн батлуулаагүй

10. Ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажил үүргийг бүрэн хэрэгжүүлж ажилладаггүй

11. Газар өмчлөлийн ажлыг эрчимжүүлэх ажил огт хийгдээгүй, газрын гэрээ дүгнэдэггүй

Дээрх хяналт шалгалт тус бүрээр дүгнэлт гаргаж Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга, Газрын удирдлагын хэлтсийн дарга нийт ажилтнуудад танилцуулж, зөвлөмж гарган, “Гүйцэтгэл сайжруулах ажлын төлөвлөгөө” гарган хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын газрын даамлуудад албан тоотоор хүргүүлж, 2017 оны 12-р сард дахин шалгалтыг хийхээр болсон. Төлөвлөгөө ёсоор дахин хяналт шалгалтыг 2017.12.13-2017.12.15-ны өдрүүдэд хийсэн.

Мөн Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын нэгдмэл, төвлөрсөн удирдлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх зорилгоор сумын Засаг даргын тамгын газрын бүтцэд ажиллаж байгаа Газрын даамлыг орон тоо, цалингийн сангийн хамт 2018.01.02-ний өдрөөс аймгийн Газрын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжүүлсэнтэй холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайдаас Засгийн газрын 2017.09.13-ны өдрийн 253 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, бэлтгэл ажлыг хангах чиглэл ирүүлсний дагуу сумдын Засаг дарга нартай санал солилцож бэлтгэл ажлыг хангуулах ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Шалгалтаар сумдын шалгуур үзүүлэлт хангалтгүй байгаа тул 2018 оны үр дүнгийн гэрээнд тусгаж, үр дүн, ажлын хариуцлагыг дээшлүүлж ажиллах зорилго тавин ажиллаж байна.

### **3. БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР ХИЙСЭН ТАЙЛАН**

### 3.1 Орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд

1000 айлын орон сууц хөтөлбөрийн хүрээнд Дархан-Уул аймагт **10914,19** сая төгрөгний өртөгтэйгээр шинээр **211** айлын орон сууц ашиглалтад орсон байна.

Үүнд:



*Сигма-Эс ХХК-ний 16 айлын  
орон сууц*



*Минж апартмент 80 айлын  
орон сууцны*



*“Дархан Шар Бүрд” ХХК-ний үйлчилгээтэй 5 давхар 45 айлын орон сууц*



*Парк Таун хотхоны 10 давхар 70 айлын орон сууц*

**3.2 Шинээр ашиглалтад орсон орон сууцны барилгын борлуулалтын мэдээ  
/ 2017.12.04-ны байдлаар /**

№	Барилга байгууламжийн нэр	Орон сууцны барилгын хүчин чадал, /айлаар/	Барилга байгууламжийн хаяг, байршил	Давхрын тоо	Өрөөний сонголт, талбай	1 м <sup>2</sup> талбайн борлуулалтын үнэ /сая.төг/	Ашиглалтад орсон хугацаа	Борлуулагдсан сууц	Борлуулагдаагүй сууц	Аймгийн хэмжээнд ашиглалтад орохоор хүлээгдэж буй орон сууц	
										Орон сууцны тоо	Айлын тоо
1	Сигма-Эс ХХК-ний 16 айлын орон сууц / 21*15м /	16 айл	Дархан сумын 14-р баг	4 давхар	2 өрөө-56м <sup>2</sup> , 3 өрөө-78-79м <sup>2</sup>	1.200.000	2017.01.27 02/2017-II	14	2	4	211
2	Минж апартамент 80 айлын орон сууц 36.6*12.5	80 айл	Дархан сумын 9-р баг	10 давхар	33.8, 41.61, 53.89, 47.59м <sup>2</sup> -2өрөө, 76.4м <sup>2</sup> -3өрөө	1.350.000	2017.02.15 04/2017-II	78	2		
3	Дархан шар бүрд ХХК 48*22	45 айл	Дархан сумын 11-р баг	6 давхар зоорьт ой	63-78м <sup>2</sup> -3 өрөө 63-65м <sup>2</sup> -2 өрөө	1.400.000	2017.02.17 06/2017-II	30	15		
4	Парк таун хотхон	70 айл	Дархан сумын 14-р баг	10 давхар	80м <sup>2</sup> , 77,3 м <sup>2</sup> -3 өрөө, 53,68м <sup>2</sup> , 49,3м <sup>2</sup> , 47,86м <sup>2</sup> , 42,79м <sup>2</sup> , 38,1м <sup>2</sup>	1'550'000	2017.12.11	68	2		

➤ “Орон сууцны тухай” хуулийн төсөлд ГХБХБГ-н мэргэжилтэн Х.Туултай хамтран Дархан-Уул аймгийн томоохон барилгажсан Парк Таун, Альфа Таун, Хүслийн хотхоны СӨХ-ны удирдлагуудтай уулзаж орон нутагт тулгамдаж байгаа саналыг цаасан хэлбэрээр хүлээн авч нэгтгэн “Орон сууцны тухай” хуулийн төсөлд саналыг БХБЯамд хүргүүлж ажилласан.

**3.3 Барилгын хувийн хэрэг хөтлөлтийн талаар:**

Барилгын хувийн хөтлөлтийн ажлыг эрчимжүүлэхээр Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн дарга Дархан-Уул аймгийн засаг




даргын орлогч Т.Ганболдоор ахлуулсан барилгын хувийн хөтлөх 1 сарын ажлын төлөвлөгөөг БХБХэлтсийн даргатай хамтран батлуулсан. Төлөвлөгөөний дагуу Дархан-Уул аймгийн мэргэжлийн хяналтын газар, Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газар, ДСЦТСтанцын мэргэжилтнүүдтэй уулзалтыг 4 удаа хэсэгчилэн сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан.



#### **3.4 Барилгын үйлдвэрлэлийн чиглэлээр:**

➤ 2017 онд нийт 22 удаагийн барилга ашиглалтад оруулах комисс ажилласан. Үүнээс Засгийн Газрын 2012 оны 12 сарын 01-ны 151-р тогтоолын дагуу 11-н удаагийн барилга ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан. /Хавсралт-2 / Засгийн газрын 68, 171-р тогтоолын дагуу 8-н удаа барилга ашиглалтад комиссд оролцож ажилласан.

Дархан-Уул аймгийн 2017 оны IV улиралд ашиглалтад орсон барилга  
байгууламжийн судалгаа




/2017.12.04 байдлаар /

Ашиглалтад орсон барилга байгууламжуудыг төрлөөр нь ангилбал:

- Нийтийн орон сууц-3
- Үйлдвэрлэл, үйлчилгээ -7
- 
- Цэцэрлэгийн барилга-1
- АХЦС, ШТС барилга-6
- Өргөтгөлийн барилга - 2

**НИЙТ: 19**

**3.5 Дархан-Уул аймагт баригдаж ашиглалтад орж байгаа орон сууцны  
барилгын эрэлт, нийлүүлэлтийн судалгаа /2012-2017 онд /**



### 3.6 Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон талаар:

Энэ онд барилга угсралтын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл хүссэн 31 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын техникийн бичиг баримтыг хянаж үзэн зөвшөөрлийг олгосон.


Үүнд:

- ✓ Нийтийн орон сууцны зориулалтаар-6,
- ✓ Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай-23,
- ✓ Малын удмын сангийн цогцолбор-1
- ✓ Спорт цогцолборын барилга-1



### 3.7 Зөрчилтэй барилга байгууламжид авсан арга хэмжээний талаар:

2017 онд барилгын ажил эхлэх зөвшөөрөл аваагүй барилга угсралтын ажил гүйцэтгэж байсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад 26 удаагийн мэдэгдэх хуудсыг өгч ажилласан. Үүнээс 11 иргэн, аж ахуйн нэгж байгууллага батлагдсан зураг төсөвгүй барилга барьж байсныг зогсоон холбогдох заавар зөвлөгөөг өгч ажилласан.



Дархан сумын Өмнөд үйлдвэрийн районд байрлах “М-Ойл” ХХК-ний ШТС нь ил үерийн шугам тагласан талаар Дархан Дулааны Цахилгаан Станц ТӨХК албан бичгийн дагуу ОБГазрын гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч ахлах байцаагч Н.Ганбаттай хамтран газар дээр нь очиж мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч, зөрчлийг арилгуулах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч зөрчлийг арилгуулж ажилласан.



/2017.01.25-ны өдөр/

Мөн Дархан сумын өмнө үйлдвэрийн районд байршилтай “HSMG” ХХК-ний нойтон хүдэр баяжуулах үйлдвэрийн гадна шугамын ажлыг барилгын ажил эхлэх зөвшөөрөлгүй аваагүй барилга угсралтын ажил хийж байсан зөрчлийн дагуу Дархан-Уул аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Барилга угсралтын улсын байцаагч Ч.Батбулгантай хамтран газар нь дээр очиж зөрчлийг хэрхэн арилгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, хугацаатай мэдэгдэх хуудасыг өгч ажилласан.



/2017.05.19 /

Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл аваагүй барилга угсралтын хийгдэж байсан мөн барилга байгууламжаа ашиглалтад оруулаагүй үйл ажиллагаа явуулж байгаа аймгийн хэмжээнд 18 иргэн, аж ахуйн байгууллагын судалгааг гаргасан. Энэхүү судалгаан дээрээ үндэслэн зөрчилтэй барилга байгууламжуудад мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэн хугацаатай мэдэгдэл хуудсыг өгч ажилласан.

**3.8 Зураг төслийн болон барилга угсралтын тусгай зөвшөөрөл шинээр авах, хугацаа сунгуулсан талаар:**

Дархан-Уул аймагт 2017 оны байдлаар барилга угсралтын тусгай зөвшөөрөлтэй 108, зураг төслийн 6 аж ахуйн нэгж байгууллага байна. Барилга угсралтын тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах, шинээр хүссэн 28 аж ахуйн нэгж байгууллагын техникийн бичиг баримтыг хянаж үзэн БХТөвд тодорхойлолтыг гаргаж өгсөн. Барилгын норм, нормативийн санд нийт 16.1 сая төгрөгийг бүрдүүлэн ажилласан.

**Барилга угсралтын тусгай зөвшөөрлийн сунгасан:**

№	Тусгай зөвшөөрөл сунгасан	Нэмэлт заалт	Норм, нормативийн санд тушаасан төг
1	Дархан Уянга ХХК	2.1.1	857000
2	Мөнх нарны сүлд ХХК		296446
3	Цагаан зуун ХХК	2.2.8	9136338
4	Дархан хясаат ХХК		442340
5	Хос гэрэгэ ХХК	2.2.4	
6	Аригшан ХХК		349710
7	Ноён өндөр констракшн ХХК		360000
8	Дархан дуулга ХХК		
9	Дархан секьютери ХХК		72000
10	Төгс Иксора		195000
11	Уран хараат ХХК	2.2.2 2.2.6	
12	Дархан цэн ган ХХК		353258
13	Дархан трейд ХХК		360000
14	Хунт Улз ХХК		114000
15	“Тегсиг” ХХК		195000
16	“Бурхант орд” ХХК		131500
17	“Сигма эс” ХХК		462050
18	“Халнит” ХХК		80600
19	“Гэрэлт гартаам” ХХК		449300
20	“Хатан хүсэл” ХХК		350000
21	“Хаш цамхаг” ХХК		100000
22	“Дархан ус суваг” ХК		212600
23	“Васт сайз констракшн” ХХК		69000
24	“Гасба” ХХК		1429200
<b>НИЙТ</b>			<b>16015342</b>

**Барилга угсралтын тусгай зөвшөөрөл шинээр авсан:**

1. Асгат Ярх ХХК,
2. Болор эрхэст цамхаг ХХК,



3. Сагч Дөш ХХК,
4. Шарын гол ТӨХК

**Зураг төслийн тусгай зөвшөөрөл сунгах:**

- “ЗТК” ХХК
- “Васт сайз констракшн” ХХК
- “ДСЦТС” ХК

**3.9 Хот байгуулалт, дахин төлөвлөлтийн чиглэлээр:**


Аймгийн Засаг дарга 2017-2020 оны хооронд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөртөө Дархан хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэх, дахин төлөвлөх тухай асуудлыг тусгасан юм. Энэхүү ажлын хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нь МХГ-ын улсын байцаагчийн дүгнэлтээр тогтоогдсон Дархан сумын 4-р багт байрлах 2, 3, 4, 5 дугаар байр, 5-р багт байрлах “Агромаш” ХХК-ний замын эсрэг талд байрлалтай 2 давхар модон бүтээцтэй тус бүр 8 айлын 7 брак байр, 6 дугаар багт байрлах 1960-1969 онуудад баригдсан хойд чиглэлийн авто зам дагуу байрлалтай 2 давхар тус бүр 8 айлтай, 8 брак байр, нийт 19 ширхэг брак байруудыг сонгосон.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Дахин төлөвлөлтийн ажлыг 2020 он хүртэл үе шаттайгаар хийж хэрэгжүүлэх бөгөөд эхний ээлжийн төсөлд хамрагдах 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар брак байрыг дахин төлөвлөхөөр ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд: Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөг танилцуулж, нийт сууц өмчлөгчдийн 23 өрх буюу 95,8%-ын зөвшөөрсөн санал авсан.

Ашиглалтын шаардлага хангахгүй болсон орон сууцны барилгыг дахин төлөвлөн



барилгажуулах нийт 4, 5, 6 дугаар багийн 19 барилгад ИТХТ-ийн 2017оны 98 дугаар тогтоол гарсан.


Үүнээс эхний ээлжийн төсөлд хамрагдах 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар байруудад ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг ажиглахыг хориглох тухай Аймгийн засаг даргын захирамж гарсаны үндсэн дээр захирамжийг иргэдэд танилцуулсан ба иргэд Засаг даргад өөрсдийн орон сууцыг дахин төлөвлөлтөнд хамруулах хүсэлтэй байгаагаа бичгээр хүргүүлсэн.



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Иргэд хүсэлтийг үндэслэн эхний ээлжид дахин төлөвлөлтөд хамрагдах 61,62,63-р байрны талаар “Ашиглалтын шаардлага хангахгүй болсон барилгыг буулгах, дахин төлөвлөн барилгажуулах тухай” 114 дүгээр тогтоол гарсан.

Дахин төлөвлөлтийн ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр “Хангайн нар” ХХК шалгаран ажиллаж байна.. Мөн Дархан сумын 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар орон сууцны байруудыг дахин төлөвлөлтөнд хамруулах ажлыг хариуцан зохион байгуулах ажлын хэсгийн төлөвлөгөө гарган ажиллаж байна.



Батлав: Ажлын хэсгийн дарга Т.Ганболд  
ДАРХАН СУМЫН 6 ДУГААР БАГИЙН 61, 62, 63 ДУГААР  
БРАК БАЙРУУДЫГ ДАХИН ТӨЛӨВЛӨЛТӨНД ХАМРУУЛАХ  
АЖЛЫГ ХАРИУЦАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ  
2017.12.12 Дархан

№	Хийж гүйцэтгэх ажил	Хугацаа	Хариуцах эзэн	Хявтран гүйцэтгэх байгууллага
1	Дархан сумын 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар брак байруудыг ашиглахыг хориглосон Засаг даргын захирамж гаргах	12/ХII	Л.Алтанчимэг Д.Ганбаяр	
2	Дархан сумын 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар брак байрууд ашиглалтын шаардлага хангахгүй болсон, дахин төлөвлөлтөнд хамруулах талаар Захиргааны ерөнхий хуулийн 15 дугаар зүйлд зааснаар оршин суугчидтай уулзалт хийж мэдээлэл өгөх, сонгох ажиллагаа	12/ХII-с өмнө	Г.Эрдэнэсүх Ц.Нямва Р.Урангуя	Дархан сумын ЗДТГ
3	Аймгийн Засаг даргын захирамжийг оршин суугчдад нь танилцуулах	13/ХII	Р.Урангуя	
4	Аймгийн Засаг даргад оршин суугчдын санал хүсэлтийг уламжлах	14/ХII	Г.Эрдэнэсүх Р.Урангуя	Дархан сумын ЗДТГ, Аймгийн ГХБХБГ
5	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар 61, 62, 63 дугаар брак байруудыг хамруулах талаар хэлэлцүүлэх	15/ХII	Т.Ганболд Д.Элдэвсайхан Д.Ганбаяр	Аймгийн ГХБХБГ
6	Дархан сумын 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар брак байрыг дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг байгуулсан шийдвэр гаргуулах	16/ХII	Л.Алтанчимэг У.Энхбат	
7	Дархан сумын 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар брак байрны оршин суугчдыг цуглуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол болон холбогдох бусад мэдээллийг хийж санал солилцох	17/ХII	Г.Эрдэнэсүх Р.Урангуя	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, Ажлын хэсэг
8	Иргэдийн төлөөллийн байгууллага байгуулах	17/ХII	Орон сууц өмчлөгчид	Ажлын хэсэг
9	Хяналтын хороо байгуулах	18/ХII	Ажлын хэсэг	АЗДТГ



10	Барилгын зураг, төслийг бэлэн болгох	25/ХII	Гүйцэтгэгч байгууллага	Д.Элдэвсайхан Д.Ганбаяр Х.Олонбаяр
11	Зураг, төслийг магадлалаар оруулан баталгаажуулах	2018 оны 01 сард	Гүйцэтгэгч байгууллага	Д.Элдэвсайхан Д.Ганбаяр
12	Гурван талт гэрээний төсөл бэлтгэх	13/ХII	Л.Алтанчимэг У.Энхбат Р.Урангуя	Ажлын хэсэг
13	Үнэлгээний хороонд өгөх техникийн тодорхойлолт бэлэн болгох	25/ХII	Б.Батсүх Д.Элдэвсайхан Д.Ганбаяр	ХОХБТХ, Ажлын хэсэг
14	Үнэлгээний хороо байгуулах	25/ХII	П.Батсүх	Ажлын хэсэг
15	Төндөр шалгаруулалтыг зэрлэх	31/ХII	Үнэлгээний хороо	Аймгийн ОНӨГ
16	Гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулж гэрээ байгуулах	2018 оны 1-р улиралд	Үнэлгээний хороо	Аймгийн ОНӨГ, ХОХБТХ
17	Гүйцэтгэгч байгууллага Дархан сумын 6 дугаар багийн 61, 62, 63 дугаар брак байрны 24 өрхтэй гэрээ байгуулах	2018 оны 1-р улиралд	ХОХБТХ	Аймгийн ОНӨГ, Ажлын хэсэг
18	Аймгийн Засаг дарга, гүйцэтгэгч байгууллага, иргэдтэй гурвалсан гэрээ байгуулах	2018 оны 1-р улиралд	Т.Ганболд Л.Алтанчимэг Д.Ганбаяр Гүйцэтгэгч байгууллага, иргэд	ХОХБТХ
19	Өр төлбөрийн судалгаа гаргах /банк санхүүгийн байгууллага, хувь иргэдээс/	20/ХII	Б.Жавхлан М.Хувьсаяа	
20	Техникийн нөхцөл авах	20/ХII	М.Анхбаатар	ДСЦТС, ДДС, "Ус сувга" ХК, МХС
21	Инженерийн 3-н байгууллагаас өртэй эсэх лавлагаа	20/ХII	М.Анхбаатар	ДСЦТС, ДДШС, ДУС
22	Орон сууц өмчлөгчдийг байрнавс нүүлгэн шилжүүлэх	2018 оны 4 сард	Гүйцэтгэгч байгууллага	Ажлын хэсэг
23	Хуучин барилга буулгах	2018 оны 4 сард	Гүйцэтгэгч байгууллага	Ажлын хэсэг
24	Барилгын ажил эхлүүлэх	2018 оны 5 сард	Гүйцэтгэгч байгууллага	Ажлын хэсэг
25	Барилгын гүйцэтгэлийн ажилд хяналт тавих	Барилга ашиглалтад орох хүртэл	Мэргэжлийн байгууллагууд	Ажлын хэсэг
26	Барилга ашиглалтад өгөх	2019 оны 1-р улирал	Гүйцэтгэгч байгууллага	Ажлын хэсэг
27	Хяналт мэдээллийн хэрэгсэлээр тухай бүр мэдээлэл хийж	Тухай бүр	С.Баяраа	Ажлын хэсэг

Жил: Энэхүү төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно

АЖЛЫН ХЭСЭГ



Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцыг буулган дахин төлөвлөн барилгажуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг 2017 оны А/476 тоот захирамжаар баталсан.



### 3.10 Гамшгаас хамгаалах байнгын ажиллагаатай зөвлөлийн чиг үүргийн дагуу хийсэн ажлын талаар:

Газар хөдлөлийн гамшгийн эрсдэлийг бууруулах комиссын Дархан-Уул аймаг дахь салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулагдсан. ГХБХБГ-н дарга зөвлөлийн орлогч даргаар томилогдсон.

- Мэргэжлийн ангийн хувьд гамшгаас хамгаалах төлөвлөгөөгөө шинэчилж батлуулсан.
- Газар хөдлөлтөд тэсвэргүй барилга байгууламжийн судалгааг гаргасан.
- Барилга байгууламжийн хувийн хэргийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулж дүгнэсэн.
- Газар хөдлөлтөд тэсвэргүй 19 орон сууцны барилгад Мэргэжлийн хяналтын газраас дүгнэлт гаргуулан дахин төлөвлөлт хамруулах талаар Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол гаргуулсан.

Шадар сайдын 2017 оны 75 дугаар тушаалыг үндэслэн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийх ажил хийгдэж байна. Онцгой байдлын газрын ГУСГ-ийн даргын 11/1121 дугаар үүргийн хүрээнд Дархан-Уул аймгийн ОБГ-аас 2017 оны 06 дугаар сарын 13-ны өдөр Гамшгаас хамгаалах мэргэжлийн

ангийн 26 удирдах бүрэлдэхүүнд 2,3 цагийн танхимын сургалтад сууж, гамшгаас хамгаалах мэргэжлийн ангийн дүрмийн төслийн хэлэлцүүлэг болж саналаа өгч ажилласан.

Мөн Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлөөс ирүүлсэн албан тоотын дагуу Дархан-Уул аймагт ашиглаж байгаа орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилгын судалгаа гаргаж хүргүүлсэн.



### 3.11 Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн талаар:

Дархан-Уул аймагт 2017 онд Барилгын материалын үйлдвэрлэл эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй **30** аж ахуйн нэгж байгууллага нийт **18** нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнээс төмөр бетон шонгийн үйлдвэрлэлээр "Си Эм Пи Ай" ХХК, бетон зуурмагийн үйлдвэрлэлээр "Сонголон хайрхан" ХХК, чулуунцар тээрэмдэх шугам бүхий цементийн "Гурван эрдэнэ цемент" ХХК, бетон гулдмай, шохойн үйлдвэрлэлээр "Силикат" ХХК зэрэг аж ахуйн нэгж байгууллагууд тусгай зөвшөөрөлөө сунгуулж, шинээр зам талбай, тохижилтийн хийцээр "Өсөх урам" ХХК, "Өсөх баян бүрд хаус" ХХК, төмөр бетон шонгийн үйлдвэрлэлээр "Хасвуу" ХХК, төмөр бетон хийцээр "Дэбүт" ХХК зэрэг байгууллагууд тусгай зөвшөөрөл шинээр авч ажилласан.

2017 оны 05, 08-р сард **2** удаа нийт **13**-н барилгын материал, үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын байрын нөхцөл байдал, технологийн дамжлага, ХАБЭА байдлыг МБМҮХолбооны экспертийн багтай хамтран үзэж, танилцаж заавар, зөвлөгөө өгч ажилласнаар **4** байгууллага тохирлын баталгаажуулалтад хамрагдаж барилгын материал үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрөл авлаа.

2017 онд шинээр "Хасвуу" ХХК-ийн бетон шонгийн үйлдвэр ашиглалтад орж "Барилтех" ХХК-ийн байгалд хаягдалгүй шохой үйлдвэрлэх бөсгөсөн шохойн үйлдвэр ашиглалтад орох бэлтгэл ажлыг хангаад байна.

Барилга байгууламжийг ашиглалтанд оруулахдаа хэрэглэсэн материал хийц, бүтээгдэхүүний гарал үүслийн гэрчилгээ, сорил шинжилгээний лабораторын дүгнэлтүүдийг иж бүрдүүлэн авч, бусад техникийн бичиг баримттай хамт архивлах ажлыг зохион байгуулж,

2017 онд ашиглалтад орсон **19** барилгын техникийн бичиг баримтуудыг архивлахаар бэлтгэл ажлыг хангаад байна.

### **3.12 Сорил шинжилгээний лабораторийн талаар:**

Дархан-Уул аймагт ДаШУТИС, Дархан төмөрлөгийн үйлдвэрийн улсын итгэмжлэгдсэн хоёр лаборатори ажиллаж байгаа бөгөөд бетоны шахалтын бат бэх, физик, механик шинж чанар, хөөцөнцөр элс дайрга шохой цемент, метал хийцийн хими хатуулаг, механик шинж чанарын дээжийн **28** нэр, төрлийн сорил шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна. Итгэмжлэгдсэн сорил шинжилгээний лабораторуудад дараах сорилт, шинжилгээ хийгдлээ. Үүнд:

- бетоны сорьцын **316ш**
- хөөцөнцөр,цемент,төмөр-бетон эдлэхүүн,шохой,хуурай хольцын **36ш**
- метал хийц,бүтээгдэхүүний **47ш**

Дархан төмөрлөгийн үйлдвэрт **10**, ДаШУТИС-д **41**, ГХБХБГ-т **7** нэр төрлийн лабораторын багаж тоног төхөөрөмжүүд ажиллаж байна.



2017.08.31.Дархан-Уул аймаг. Үйлдвэрийн дүүрэг, БМҮХ-ийн шинжээчдийн баг, зөвлөх инженер Д.Эрдэнэчимэг, Б.Жалбий-Юмчин, Д.Доржготов нар “Силикат”ХК-ийн захирал Содбилэгийн ажлын байранд

2017. 08.31.Дархан-Уул аймаг.Үйлдвэрийн дүүрэг.БМҮХ-ийн шинжээчдийн баг “Гурван эрдэнэ цемент”ХК-ийн цементийн үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөлгөө өгч байгаа байдал



2017.09.01. Дархан-Уул аймаг. Дархан 5-р баг. БМҮХ-ийн шинжээчдийн баг “Өсөх урам” ХХК-ийн явган замын хавтан, хашлаганы үйлдврийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөлгөө өгч байгаа байдал



2017.09.01. Дархан-Уул аймаг. Хонгор сум. БМҮХ-ийн шинжээчдийн баг “Идэр хайрхан” ХХК, “Тулгат шийр” ХХК –ийн шохой, хайрганы үйлдврийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөлгөө өгч байгаа байдал



2017.09.01. Дархан-Уул аймаг. Хонгор сум. БМҮХ-ийн шинжээчдийн баг “Барил тех” ХХК –ийн бөгсөрсөн шохойн үйлдврийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөлгөө өгч байгаа байдал



2017.05.25. Дархан-Уул аймаг, Дархан сум, 8-р баг ГХБХБГ, МБМУХолбооны экспертийн багийн  
, БМУ-лэл эрхэлдэг ААНБ-ын төлөөлөлын хамтарсан хурал,

“Сан-Орги” ХХК-ийн бүтээгдэхүүний агуулах



### 3.13 Захиалагчийн техник хяналтын талаар

2017 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын барилга угсралт, их засварын чиглэлээр 4 байршилд баригдаж дууссан нийт 5.9 тэрбум төгрөгний гүйцэтгэлийг хянаж баталсан.



**Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын багцад батлагдсан концессийн гэрээгээр 1,3 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэйгээр** Дархан-Уул аймгийн 5-р багт байршилтай “Жинсийн орой” ХХК-ний гүйцэтгэсэн 100 хүүхдийн цэцэрлэг барилгад захиалагчийн техник хяналтыг гэрээний дагуу хийж ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан.



3,04 тэрбум төгрөгний өртөгтэй Дархан-Уул аймгийн ШУТИС-ийн 1600 оюутны багтаамжтай өргөтгөлийн барилга ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан.

Эрүүл мэндийн яамны сайдын 2016 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн А/109 дугаартай Барилга угсралтын ажилд захиалагчийн техник хяналт хийх тушаал дагуу Дархан-Уул аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар нь Дархан сумын 13-р багийн нэгдсэн эмнэлэгийн цусны салбар банкны барилгын засварын ажилд захиалагчийн хяналт хийх ЗХ-2016/1 дугаартай гэрээг 2016 оны 11 дүгээр сарын 19-ны өдрөөс 2017 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэхээр **48 995 172** / дөчин найман сая есөн зуун ерэн таван мянга нэг зуун далан хоёр төгрөг / барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгон ашиглалтад оруулах комиссыг зохион байгуулж ажилласан.

**Дархан сумын 12-р багт байрлалтай Спорт цогцолборын барилгад 2017 онд 1,5 тэрбум төсөв өртөгтэй ажилд захиалагчийн техник хяналтыг гүйцэтгэн ажилласан.**


21 аймгийн төвийн 1000 айлын орон сууцны хорооллын инженерийн шугам сүлжээ" төсөл, арга хэмжээний багц 3 буюу манай аймагт хийгдсэн байнга гэмтэл гарч байгаа 13 цэгт хийх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажлуудын гүйцэтгэлийн тухай БХБЯ-с ирсэн төлөөлөлд танилцуулсан. Нийт 13 цэгт шугам шинэчлэхээс 2014-2016 онд 11 ажлыг бүрэн дуусгаж энэ онд 9-р багийн нутаг дэвсгэрт 4.4-р байрнаас 4.6-р байр хүртэлх шугам

шинэчлэлтийн ажил бүрэн хийгдэж, Дархан сумын 6, 7-р багийн нутаг дэсгэрт Монгол алтны уулзвараас Дархан хүнсний уулзвар хүртэлх усан хангамжийн төв шугамыг шинэчлэх ажил цаг агаар хүйтэрсэнтэй холбоотой хойшлогдсон.

Мөн Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 136 дугаар тогтоол, Концессын гэрээгээр “Дулаан шарын гол” ТӨХК-ийн Дулааны худаг 2-оос дулаан хуваарилах төвийн барилга хүртэл 1853м Ф200мм хос цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажлыг “Бурхантхясаат” ХХК 100% хийж гүйцэтгэсэн.

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 136 дугаар тогтоол, Концессын гэрээгээр К14-К27 дугаар худгийн хоорондох 2.7км хос Ф600 мм дулааны төв шугамыг шинэчлэн солих 4,6 тэрбум төгрөгийн өртөг бүхий ажлыг “Одкон холдинг” ХХК нь шалгаран К14-К18 хүртлэх 1.2 км хос 2017 онд хийж гүйцэтгэсэн. К18-К27 хүртлэх 1.5 км хос шугамын шинэчлэлийн ажлыг 2018 онд хийж гүйцэтгэнэ.

### **Байнга гэмтэл гарч байгаа 13 цэгт хийх цэвэр усны шугамын шинэчлэлтийн ажлуудын**



Гүйцэтгэгч - Альянс тех ХХК  
Зураг төсөл - Инж байгууламж ХХК  
Төсөвт өртөг – 2.19 тэрбум төгрөг  
Ажил эхэлсэн хугацаа – 2014 он  
Ажил дууссах хугацаа – 2017 он  
Гүйцэтгэл – 86%

Дархан сум хэмжээнд 2014-2016 оны хооронд нийт 10 цэгт шугам шинэчлэлтийн ажил хийгдсэн. 2017 онд 2 байршилд шугам шинэчлэлтийн ажил хийгдэхээс 9-р багийн нутаг дэвсгэрт 4.4-р байрнаас 4.6-р байр хүртэлх 437м урттай Ф200мм шугам шинэчлэлтийн ажил бүрэн хийгдэж дууссан. Дархан сумын 6, 7-р багийн нутаг дэсгэрт Монгол алтны уулзвараас Дархан хүнсний уулзвар хүртэлх L=1311м газарт Ф300мм ус хангамжийн төв шугамыг шинэчлэх ажил цаг агаар хүйтэрсэнтэй холбоотой хойшлогдсон.

**Угсралтын үеийн фото зураг**



**“Дулаан шарын гол” ТӨХК-ийн Дулааны станцаас Ус дулаан дамжуулах төв хүртэлх  
дулаан, цэвэр усны шугамын өргөтгөл шинэчлэлт ажил**



**Дархан сум К14-К27 дугаар худгийн хоорондох 2.7км хос ф600 мм дулааны төв  
шугамыг шинэчлэн солих**



Гүйцэтгэгч - Одкон холдинг ХХК  
Зураг төсөл - Эрчим төсөл ХХК  
Төсөвт өртөг – 4.6 тэрбум төгрөг  
Ажил эхэлсэн хугацаа – 2017 он  
Ажил дуусгах хугацаа – 2018 он  
Гүйцэтгэл – 35%





### 3.14 “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх.

“Ус” үндэсний хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран орон нутгийн түвшинд зохион байгуулж, биелэлтийг хагас жилийн байдлаар гаргаж БХБЯ, БХТ болон аймгийн ХОХБТХэлтэст албан тоотын хамт хүргүүлэн ажилласан. Жилийн эцсийн тайланг 2018 оны 1-р сард гаргаж явуулна.

### 3.15 Дархан хотын бохир усны менежмент сайжруулах төсөл мон3244/3245 төсөл

- Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төслийн ажлууд үргэлжлэн А2/1 багц буюу ДДС ТӨХК-ийн насосны станц 3-ын тоног төхөөрөмжийн шинэчлэл болон Төв цэвэрлэх байгууламж руу дулааны шугам татах ажилд “Хүрд” ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна. А2/2 багц буюу бохир усны шугам шинэчлэл, өргөтлийн ажилд “Бридж констракшн” ХХК шалгаран 6 багц ажлын 2 багц ажлыг 100% дуусгаж, 2 ажил 65%, 2 ажил эхлээгүй 2018 онд хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж ажиллаж байна. Энэ төсөл хэрэгжсэнээр Дархан хотод 4,8 км урт бохир усны шугам шинэчлэгдэж 24-30 мян м<sup>3</sup> хүчин чадалтай орчин үеийн техник, технологитой шинэ цэвэрлэх байгууламж ашиглалтад орох болно. МОН-3244/3245 төсөл нь Азийн хөгжлийн банкны /хөнгөлөлттэй зээл/ хөрөнгө оруулалтаар хэрэгжих болно.



### Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах МОН-3244/3245 төсөл

МОН-3245 төслийн хүрээнд 6 байршилд бохир усны шугам засварлаж шинэчлэх ажил хийгдэхээс

- А1 хэсэгт 1333м шугам хоолойг хэсэгчлэн засварлаж шинэчлэх. 2018 онд гүйцэтгэнэ
- А2 хэсэг 1580м шугам хоолойг хэсэгчлэн засварлаж

шинэчлэх. Ажлын гүйцэтгэл 45%

- А3 хэсэгт 1325м шугам хоолойн уртын дагууд цэвэрлэж худаг засварлах. Ажлын гүйцэтгэл 100%
- А4 хэсэгт 1230м шугам хоолойг хэсэгчлэн засварлаж лайдаж цэвэрлэх. Ажлын гүйцэтгэл 85%
- А5 хэсэгт 343 м шугам хоолойг шинэчлэх
- А6 хэсэгт 211м шугам бохир усны шугамыг шинээр хийх. Гүйцэтгэл 100%

### Дархан хот бохир усны менежмент сайжруулах төслийн ажлын хэсгийн хуралд оролцсон



Ажлын хэсгийн хурал нь сар бүрийн сүүлийн ажлын өдрийн 14 цагт аймгийн ЗДТГазрын хурлын танхимд болдог. Энэ хурлаар ажлын гүйцэтгэл санхүүжилт тулгамдаж байгаа асуудлын талаар хэлэлцсэн.

Ажлын гүйцэтгэлийн үеийн зурагнаас



А3 хэсэгт



А2 хэсэгт



А4 хэсэгт

#### 4. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ТАЛААР

Байгууллагын үйл ажиллагаагаан ил тод иргэн, хуулийн этгээдэд нээлттэй сурталчлах талаар тодорхой ажил, арга хэмжээнүүдийг шат дараалан авч хэрэгжүүлж байна. Үүнд:

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар байгууллагын цахим хуудсаар 158 төрлийн мэдээ мэдээллийг оруулсан.

ГХБХБГ-ын цахим хуудсанд байршсан мэдээллүүд



2017 оны 03 дугаар сарын 21-ны өдрийн А/07 тоот тушаалаар байгууллагын санал хүсэлт хүлээн авах, нээлттэй утас ажиллуулах журмыг боловсруулан батлуулж, байгууллагын цахим болон фэйсбүүк хуудас, Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдын Газрын даамлуудын ажлын байранд 7037-6471 дугаартай нээлттэй утасны зурагт хуудаснууд байршуулсан. Нээлттэй утсаар өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор 250 орчим иргэнд мэдээлэл зөвлөгөө болон өргөдөл хүсэлтийн хариуг өгч ажилласан байна.

Мэдээлэл зөвлөгөө хүлээн авах ажлын бэлэн байдал



Байгууллагын 7 хоног, сарын, хагас, бүтэн жилийн тайлангуудыг байгууллагын цахим [www.darkhan.gazar.gov.mn](http://www.darkhan.gazar.gov.mn) хуудасны ил тод хэсэгт нээлттэй тогтмол оруулж хэвшсэн.

ГХБХБГ-ын цахим хуудсанд байгууллагын үйл ажиллагааг тайлагнаж буй байдал

Он сар	Файл
2017 оны 1-р сарын 1 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 1-р сарын 2 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 1-р сарын 3 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 1-р сарын 4 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 2-р сарын 1 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 2-р сарын 2 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 2-р сарын 3 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 3-р сарын 1 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 3-р сарын 2 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 3-р сарын 3 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 3-р сарын 4 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 4-р сарын 1 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 4-р сарын 2 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 4-р сарын 3 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 5-р сарын 1 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 5-р сарын 2 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 5-р сарын 3 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 5-р сарын 4 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 5-р сарын 5 дугаар 7 жног	Тайлан татах
2017 оны 6-р сарын 1 дугаар 7 жног	Тайлан татах

САРЫН ТАЙЛАН

Он сар	Файл
2017 оны 1-р сар	Тайлан татах
2017 оны 2-р сар	Тайлан татах
2017 оны 3-р сар	Тайлан татах
2017 оны 4-р сар	Тайлан татах
2017 оны 5-р сар	Тайлан татах
2017 оны 6-р сар	Сарын тайлан гараагүй байна
2017 оны 7-р сар	Сарын тайлан гараагүй байна
2017 оны 8-р сар	Сарын тайлан гараагүй байна
2017 оны 9-р сар	Сарын тайлан гараагүй байна
2017 оны 10-р сар	Сарын тайлан гараагүй байна
2017 оны 11-р сар	Сарын тайлан гараагүй байна
2017 оны 12-р сар	Сарын тайлан гараагүй байна

Байгууллагын серверийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах зорилгоор 2017 оны 05 дугаар сард хуучин бараа материал хадгалах агуулахад ажиллаж байсан 3 серверийг шилжүүлж тодорхой стандарт, аюулгүй байдлыг хангасан өрөөнд шилжүүлэн суурилуулж, серверийн ракуыг иж бүрэн угсарч серверүүдийг хийсэн. Мөн салангад тус тустай байсан холбогдох тоног төхөөрөмжүүд /шилэн кабель, сүлжээний свич, роутер, сүлжээний кабель, хөргүүр/-ийг хэвийн ажиллагааг хангахаар бүгдийн нэг дор оруулж зохион байгуулсан.

ГХБХБГ-ын серверийн тоног төхөөрөмж



2017 оны 04 сард Дархан-Уул аймгийн Дархан, Хонгор, Шарын гол, Орхон сумдуудын Газрын даамлуудад 4-н ширхэг цахим хурлын камерын худалдан авалтыг хийж энэ ажлын хүрээнд 07 дугаар сарын 19-нд Дархан-Уул аймгийн Хонгор, Орхон, Шарын гол сумдын Газрын даамлуудтай онлайн цахим хурлын камерыг турших ажлыг амжилттай зохион байгуулж хийсэн.

Онлайн цахим хурал



Мөн 2017 оны 08 дугаар сарын 10-нд ГЗБГЗЗГ, 21 аймгийн ГХБХБГ-тай цаг үеийн асуудлаар цахим видео хурлыг зохион байгуулж, дараа нь сумдын газрын даамлуудтай цаг үеийн асуудлаар цахим видео хурлыг хийж үүрэг даалгавар өгсөн.

Цахим видео хурал



➤ **Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажилласан**

2016 онд газар эзэмших, өмчлөх эрхийн гэрчилгээ нь хүчингүй болсон иргэн, хуулийн этгээдэд захиргааны ерөнхий хуулийн дагуу сонсгох ажиллагаа хийх гэж байгаа тухай, мөн газар эзэмших гэрээтэй мөртлөө олон жил газраа ашиглаагүй байгаа иргэн, хуулийн этгээдээр газар ашиглалтын төлөвлөгөөг гаргуулан санамж бичиг байгуулах, 70376471 дугаартай нээлттэй утас ажиллаж эхэлсэн тухай, газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж байгаа тухай зэрэг мэдээллүүдийг орон нутгийн Ди би эс, ЛХА, Аа жи би, ТҮ-12 телевизүүдээр 9 удаа зохион байгуулах ажлыг хийсэн.



Мөн газар эзэмших эрхийн гэрчилгээний 5 удаагийн дуудлага худалдааны зарыг үндэсний өдөр тутмын Өдрийн сонинд 2017.04.14-ны №084, 2017.05.26-ны №118,



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2017.07.17-ны №152, 2017.10.09-ны №217 дугааруудад тус тус заруудыг хэвлүүлэх ажлыг зохион байгуулсан.



➤ **Google тар-т манай байршил орсон.**

Интернэтэд Google тар програмд байгууллагын байршил, холбоо барих утасны дугаар, цахим хаяг, ажиллах цагийн хуваарийг оруулж бүртгүүлсэн. Ингэснээр манай байгууллагын мэдээллийг онлайнаар хайхад байршлыг мэдэх, утас, цахим хуудаснаас мэдээллийг авах боломжтой болсон.



➤ **Хууль сурталчлах ажлын хүрээнд сургалт зохион байгуулсан.**

Хууль сурталчлах ажлын хүрээнд аймгийн хууль, эрх зүйн хэлтэстэй хамтран албан хаагчдынхаа дунд нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтыг 2017 оны 3 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулсан.



### 1.1. Нээлттэй хаалганы өдөр зохион байгуулсан

➤ 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр Дархан Олон улсын худалдааны төвийн гадна талбайд нээлттэй хаалганы өдрийг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж үүнд кадастрын зураг, газар өмчилж аваагүй тодорхойлолт, газрын төлбөрийн мэдээлэл, лавлагаа г.м, нээлттэй хаалганы өдрөөр зөвлөгөө мэдээллийг нийт 74 иргэнд өгч, 5-н төрлийн 150 ширхэг гарын авлагыг хэвлэн иргэдэд тараасан.



#### ➤ Байгууллагынхаа гадна орчны цэвэрлэгээг зохион байгуулсан

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 02 дугаартай албан даалгавар, Дархан сумын Засаг даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/93 даалгаврын хүрээнд аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар өөрийн дотоод болон ойролцоох орчны 50 метр зайд зам, талбайн хогийг цэвэрлэх ажлыг 2017 онд зохион байгуулж хийлээ.



Байгууллагынхаа ногоон байгууламжийг нэмэгдүүлж 18 ширхэг цэцгийн сав, усны савыг шинээр авч цэцэг тарьж тохижуулсан.



Байгууллагын 20 жилийн ойн бүтээлч ажлын хүрээнд

А. Угтах үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн.



Б.Хамт олноороо Дугуйн аялал зохион байгуулсан.



В. Байгууллагынхаа гадна явган зам талбай, гэрэлтүүлэг, фасадны засвар шинэчлэлтийн ажлууд хийсэн







**Нийгмийн хариуцлагын хүрээнд санаачлан хийсэн ажилууд:**

А. Дархан сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэн Э.Шинэбаяр хүүд 7-р баг Зурагтын ар 2-16 тоотод гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар олгож сэтгэлийн дэм өгсөн.

Б. Дархан сумын Малчин багийн иргэн өрх толгойлсон эмэгтэй Э.Мөнхцэцэгт туслах ажилд Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, БОАЖГ, ГХБХБГ, Ус цаг уур орчны шинжилгээний алба, Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, Дархан хот байгуулалт барилга захиалагчийн газар, Дархан зам тээвэр, ХХААГ, Янжмаа захиралтай Хангай захын захиргаа, иргэн Отгонсүрэн нар хамтран гэр бүлийн хэрэгцээнд зориулалттай 627 м2 талбайтай өмчлөлийн газрын гэрчилгээг олгохын зэрэгцээ хашааг барьж өгсөн.





В. Дархан-Уул аймгийн Дархан сумын 15-р багийн иргэн 16 настай Д.Мөнгөншагай нь аав, ээж 4-н дүү, ихрийн хамт амьдардаг бөгөөд тэдний амьдарч байсан байшин нь 2015 оны 11 сард шатаж орох оронгүй болж, өөрийн гэсэн газаргүй өнөөдрийг хүртэл сүмийн байранд аав, ээжийн хамт амьдралын хүнд нөхцөлд амьдарч байгаа бөгөөд одоогоор 3-н дүү нь асрамжийн газарт амьдарч байна.

Иймд Мөнгөшагай охины гаргасан хүсэлтийг аймгийн ГХБХБГ-ын ах эгч нар нь судлаж нийгмийн хариуцлагын хүрээнд Мөнгөншагай охиныг газартай болгож гэрчилгээг нь гардуулан өглөө.



Г. Дархан сумын 10 дугаар багийн иргэн Д.Ишгомбо хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй ч тэр хувиараа өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг. Нийгмийн асуудлыг нь шийдвэрлэж өрхийн хэрэгцээний газрыг шийдвэрлэж өглсөн.



## 5. ӨРГӨДӨЛ ГОМДЛЫН ШИЙДВЭРЛЭЛТИЙН ТАЛААР

2017 оны 12 дугаар сарын байдлаар Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт бичиг хэрэг, архивын ажилтнаар дамжуулан нийт 1287 албан бичиг ирсэнээс хариутай 695 үүнээс шийдвэрлэсэн 648, хяналтанд байгаа 37 бичиг, хугацаа хэтэрсэн 10 бичиг, хариугүй 592 бичиг бүртгэгдсэн байна. Хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн түвшин 93,24% хувьтай байна. Доорх хүснэгтээс харахад нийт ирсэн бичгийн шийдвэрлэлт нь хяналтанд байгаа 38 бичгээс хамааран 93,1 хувьтай байна.

Ирсэн бичгийн тайлан /2017.01.02 - 2017.12.01/

Албар хэлтэс	Бүгд	Хариутай					Хариугүй		Байгуул лагад эзлэх хувь
		Нийт	Шийдвэр -лэсэн	Шийдвэр -лэлтийн хувь	Хяналтанд байгаа	Хугацаа хэтэрсэн	Нийт	Шийдвэр -лэсэн	
Удирдах ажилтнууд	183	53	48	90.57%	3	2	130	32	14,15
Газрын удирдлагын хэлтэс	828	515	482	93.59%	26	7	313	100	64,04

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Барилгын хэлтэс	277	128	118	92.19%	9	1	149	79	21,42
<b>Бүгд</b>	<b>1288</b>	<b>696</b>	<b>648</b>	<b>93.1%</b>	<b>38</b>	<b>10</b>	<b>592</b>	<b>211</b>	<b>100</b>

➤ 2017 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар бичиг хэрэг, архивын ажилтан нь иргэн, хуулийн этгээдээс байгууллагад хандсан нийт 1030 өргөдөл хүсэлт хүлээн авсан байна. Үүнээс иргэн, хуулийн этгээдийн 933 өргөдөл гомдлыг барагдуулсанаас 3 өргөдөл хугацаа хэтрүүлэн шийдвэрлэжээ. Шийдвэрлэх шатанд 80 өргөдөл судлагдаж байна.

**Байгууллагад ирсэн өргөдлийн тайлан /2017.01.02 – 2017.12.01/**

Салбар хэлтэс	Бүгд	Хариутай	Шийдвэрлэсэн	Хяналтанд байгаа	Хугацаа хэтэрсэн	Шийдвэрлэлтийн хувь
Удирдах ажилтнууд	114	113	113	0	0	100%
Газрын удирдлагын хэлтэс	908	895	812	80	3	90,73%
Барилгын хэлтэс	8	8	8	0	0	100%
<b>Нийт</b>	<b>1030</b>	<b>1016</b>	<b>933</b>	<b>80</b>	<b>3</b>	<b>91,83%</b>

**Хүлээн авсан өргөдлийн шийдвэрлэлт /2017.01.02 – 2017.12.01, хувиар/**



Мөн байгууллагын ажилтан, албан хаагчдаас 14 өргөдөл ирсэн бөгөөд ажлаас чөлөөлөх, чөлөө хүсэх, ажилд орох, томилолтын мөнгө хүсэх, түлээ нүүрсний хөнгөлөлт хүсэх зэрэг хүсэлт байсан ба тухай бүрт нь хүсэлтийг шийдвэрлэжээ.

➤ Албан хэрэг хөтлөлт, архивын ажлыг сайжруулах зорилгын хүрээнд энэ оны 10 дугаар сард Дархан-Уул аймаг дахь Төрийн архиваас Засаг даргын дэргэдэх агентлаг, төрийн болон

төрийн өмчит байгууллагуудын архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг хамруулан “Архивын ажлын онол, арга зүй” сэдэвтэйгээр зохион байгуулсан сургалтад хамрагдлаа.

Дархан-Уул аймгийн бичиг хэрэг, архивын ажилтнуудын “Архивын ажлын онол, арга зүй” сэдэвт сургалтын үер



➤ Албан хэрэг хөтлөлт, дотоод ажлыг сайжруулах зорилгын хүрээнд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсээс зохион байгуулсан 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газруудын архив бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан ажилтнуудыг хамруулсан 2 өдрийн албан хэрэг хөтлөлт, хүний нөөц, абле клоүд программын хичээлийн хөтөлбөртэй богино хугацааны сургалтад хамрагдсан.



## 6. ТӨРИЙН НУУЦЫН ХАДГАЛАЛТ, ХАМГААЛАЛТЫН ТАЛААР

ГХБХБГ-ын даргын 2016 оны 11дүгээр сарын 21 өдрийн А/76 тоот тушаалаар томилогдсон Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийн тоолох комисс Тагнуулын хэлтсийн мэргэжилтэн Д.Баярсайхантай хамтран Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийн толлогыг хийж гүйцэтгэлээ. “Төрийн нууцыг хамгаалах журам”-ын 8.1.3-т заасаны дагуу Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, биет зүйлийн

тооллогыг орон нутгийн Тагнуулийн газартай хамтран зохион байгуулж, тооллогын бүртгэлийн дүнг маягт № 9, 10-ын дагуу ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн.

Нууц материал авч ашиглах эрх бүхий хүмүүсийн итгэмжлэлийг сунгах, баталгааг шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Байгууллагын **13** ажилтнаар баталгаа гаргуулсан.

2017 оны 11 дүгээр сарын 29-нд Дархан суманд зохион байгуулагдсан Төрийн болон албаны нууцын тухай хууль /2016 оны 12 дугаар сарын 01/ тогтоомжоор хийсэн сургалт семинарт оролцлоо.

## **7. ТӨСӨВ, САНХҮҮ, ШИЛЭН ДАНСНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ**

Аймгийн Газрын харилцаа, Барилга, Хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Ганбаяр, ахлах нягтлан бодогч Б.Мөнгөтогос нар 2017 оны санхүүгийн үйл ажиллагаанд 1, 2-р гарын үсэг зурж, 2017 оны 11 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар санхүүгийн байдал, уг өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг материаллаг байдлын хувьд үнэн зөв илэрхийлж тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Төсвийн тухай” хуулийн заалтын дагуу үнэн зөв тусган, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэн ажиллалаа.

Тус байгууллага нь энэ тайлангийн хугацаанд /2017 оны 4-р улирлын байдлаар/ газрын дарга, гүйцэтгэх, үйлчилгээний ажилтан гэсэн бүтэцтэйгээр, удирдах ажилтан 1, гүйцэтгэх ажилтан 12, үйлчлэх ажилтан 5 нийт 18 орон тооны бүрэлдэхүүнтэй албан үүргээ гүйцэтгэлээ.

### ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ **ЗАРДЛЫН 100190029001** ДАНСНЫ ТУХАЙ

2017 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн Сангийн яамнаас Төрийн сангийн дансуудад 3 орон тоо нэмэгдүүлсэнээр Дархан-Уул аймгийн ГХБХБГазрын 100190029001 тоот данс болон өөрчлөгдсөн.

Санхүүжилтийн төрөл:

- ✦ Тусгай зориулалтын сангаас 237'102'500,00 төгрөгийн,
- ✦ Нийгмийн Даатгалын сангаас 3'187'197 төгрөгийн санхүүжилт,
- ✦ ГЗБГЗЗГазраас Хөрөнгийн санхүүжилтээр 6'696'960,00 төгрөгийн бараа материал агентлагаас захиалж ханган нийлүүлж ажилчдын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангасан. Үүнд:
  - 6000 ш нууцлал бүхий цаас,
  - 1100ш нэгж талбарын хувийн хэрэг,
  - 1000ш гэр бүлийн хамтын хэрэгцээний газар эзэмших эрхийн гэрчилгээ,
  - 200ш ААНБайгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ
  - 100ш Төрийн байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээ

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

- ★ ГЗБГЗЗГ азраас Хөрөнгийн санхүүжилтээр 21'199'000,00 төгрөгийн Үндсэн хөрөнгө. Үүнд:
  - 3 сумдын даамлуудад 3 ш иж бүрэн компьютер, 3 ш принтер, 1ш ток баригч 7'999'000.00 төгрөгийн машин тоног төхөөрөмж
  - Албаны хэрэгцээнд 13'200'000.00 төгрөгийн Тоёото Беривис маркийн суудлын автомашиныг баланс тайланд бүртгэж авлаа.

/Спидометрийн заалт 161390/-аар хүлээж асан

1. ТЕХНИКИЙН ТӨВӨРГӨНГӨ  
2. 3. ТАТВАР, ТӨВӨРГӨНН ТЭМДЭГЭЭЛ

ТЕХНИКИЙН ХАЙЛЧЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

Автомашинд хийсэн техник үйлчилгээ

Техник үйлчилгээ	Нэр торол	Тоо
<input checked="" type="checkbox"/> Хөдөлгүүрийн тос, шүүр	5л/11 р/40 5л	5000 ам да 7000
<input type="checkbox"/> Автомат хураны хайрдагийн шингэн		Хол ямар ч үгүй
<input type="checkbox"/> Механик хураны хайрдагийн тос		Автомат, галт
<input type="checkbox"/> Хөдөлгүүрийн шингэн		Автомат, галт
<input type="checkbox"/> Галдрын шингэн		7000
<input type="checkbox"/> Резуктор болон туслах кролын тос		7000
<input type="checkbox"/> Тухайн шүүр, бензин шүүр		Хийсэн
<input type="checkbox"/> Свече		
<input type="checkbox"/> Хөдөлгүүрийн хаалт		
<input type="checkbox"/> Тогроолны наклаа, шингэн		
<input type="checkbox"/> Хөдөлгүүр		
<input type="checkbox"/> Хүч дамжуулах анги		
<input type="checkbox"/> Тумгуур за анги		
<input type="checkbox"/> Шахмгаан засвар		
<input type="checkbox"/> Бусад		

Тухайн үеийн км-ийн заалт 162150  
Үйлчилгээ хийсэн механик [Signature]  
20. 12. 10 он сар 20 өдөр



Дараах засвар үйлчилгээг хийсэн:

1. Тосол /10л/
2. Моторын масло /6л/
3. 4 ширхэг өвлийн дугуй /195\*65\*15/


771300 төгрөгийн техник үйлчилгээ хийсэн байна.

2016 оны 3 сарын 20-нд санта фе /Улсын дугаар: 0548ДАХ/ авто машинд дараах засвар үйлчилгээг хийсэн:


1. 4 ширхэг дугуй
2. Моторын тос
3. Тормозын накладыг сольж үйлчилгээг цаг тухайд гүйцэтгэсэн. Уг авто машин нь кроп эвдэрсэн учраас ашиглагдахгүй зогссон.

Хагас жилийн байдлаар олгогдсон 237.1 сая төгрөгийн санхүүжилтийн 67.0% нь цалингийн сан эзэлж байна.

## 2017 оны төсөв



Батлагдсан төсвийн хуваарийн дагуу Төрийн сангийн 100190029001 дансаар 237.1 төгрөгийн санхүүжилт авч 237.1 төгрөг зарцуулж ажиллаа.



2017 оны 1-12-р сарын Төсвийн санхүүжилт, зарцуулалтын тайланг өссөн дүнгээр сар бүрийн 01-ны байдлаар гаргаж тогтмол боловсруулж САРЫН мэдээг аймгийн Төрийн сан банкинд цаасан хэлбэрээр хүргүүлэн зардал болон үлдэгдлийг баталгаажуулсан. Хүлээн авсан гарын үсэг тамгаар баталгаажуулан ГЗБГЗЗГазарт цахим болон факсаар хүргүүлсэн. Сарын мэдээнд:

- Үндсэн үйл ажиллагааны дансны
- Нэмэлт санхүүжилтийн дансны
- Мөнгөн кассын тайлан
- Кассын дансны хуулга зэргээс бүрдэн тайлагнадаг. **Нийт 12 удаа мэдээлсэн.**

- Төсвийн ил тод, Шилэн дансны хуулийг мөрдөж сар бүрийн 2-ны дотор төсвийн гүйцэтгэлийн мэдээг аймгийн Төрийн сангийн хэлтэст тайлагнахаас гадна



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

[www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад нийт 12 удаа шивж оруулсан. Үүнээс гадна Төсвийн ил тод хуулийг мөрдөж сар бүрийн 2 дансны орлогыг ангилж боловсруулсан мэдээ, жилийн эцсийн тайлангийн аудитын дүгнэлт болон эхний хагас жилийн баталгаажсан санхүүгийн тайланг санхүүгийн мэдээллийн самбарт байршуулан нийтэд тогтмол шинэчилэн ил тод мэдээлж байна. Албаны сайтад сарын мэдээг скайнердан pdf файлаар хавсаргаж мэдээлсэн. Эндээс татаж авах хэвлэх боломжийг бүрдүүлсэн болно. Мөн сайтын холбоосыг [www.darkhan.gazar.gov.mn](http://www.darkhan.gazar.gov.mn) сайтад шууд холбуулсан.

Цаг үеийн мэдээ тайлангуудыг заагдсан хугацаанд багтааж гүйцэтгэлийн тайлан, хугацаат мэдээ, судалгаануудыг холбогдох газруудад хүргүүлэн ажиллаж байна.

2018 оны төсвийн төсөл, 2019-2020 оны төсвийн төсөөлөл болон хөрөнгө оруулалтын зардлыг төсөвлөх саналаа 2017.06.27-ны өдөр ХАМТ ОЛНЫ ХУРЛААР ХЭЛЭЛЦЭН тооцоог хариуцсан мэргэжилтэн бүрээс авч тусган гүйцэтгэн, 2018 оны төсвийн төслийг боловсруулж 2017 оны 6-р сарын 29-ний өдөр №525 албан тоотор ГЗБГЗЗГазарт хүргүүлсэн.



<b>Дархан-Уул аймгийн ГХБХБГазрын 2018 оны төсвийн үрсгал зардлын товч</b>			
<b>Эдийн засгийн ангилал</b>			
	2018 оны	2019 оны	2020 оны
<b>II.Нийт зардлын дүн</b>	2,643,434.81	462,723.08	608,866.39
<b>IV.Урсгал зардлын дүн</b>	2,643,434.81	462,723.08	608,866.39
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	<b>2,625,654.6</b>	<b>459,883.1</b>	<b>505,871.4</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>289,393.4</b>	<b>318,332.7</b>	<b>350,166.0</b>
<b>Үндсэн цалин</b>	<b>174,188.6</b>	<b>191,607.5</b>	<b>210,768.2</b>
Нэмэгдэл	50,307.0	55,337.7	60,671.5
Гэрээт ажилын цалин	45,757.8	50,333.5	55,366.9
Урваг хөдөлмөний хөнгөлөлт	19,140.0	21,054.0	23,159.4
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 10%</b>	26,916.3	29,608.0	32,568.8
Тэтгэврийн даатгал 7%	20,257.5	22,283.3	24,511.6
Тэтгэмжийн даатгал 0.5%	1,447.0	1,591.7	1,750.8
УОМШ өвчний даатгал 1%	2,893.9	3,183.3	3,501.7
Ажилгүйдлийн даатгал 0.5%	1,447.0	1,591.7	1,750.8
Эрүүл мэндийн даатгал 2%	870.9	958.0	1,053.8
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	10,486.7	11,535.4	12,689.0
Гэрэл, цахилгаан	3,270.4	3,597.4	3,957.2
Гулш, халаалт	4,670.6	5,137.7	5,651.4
Цэвэр, бохир ус	967.8	1,064.5	1,171.0
Байрны түрээсийн төлбөр	1,578.0	1,735.8	1,909.4
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	35,783.6	39,361.9	43,298.1
Бишиг хэрэг	7,173.8	7,891.2	8,680.3
Тээвэр, шатахуун	16,984.0	18,682.4	20,550.6
Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	11,185.8	12,304.4	13,534.8
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	440.0	484.0	532.4
Нормативт зардал	120.0	132.0	145.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	120.0	132.0	145.2
<b>Эд хөгжил, урсгал засварын зардал</b>	1,439,280.8	38,550.0	42,405.0
Урсгал засвар	30,500.0	33,550.0	36,905.0
Эд хөгжил худалдан авах	1,408,780.8	5,000.0	5,500.0
Омилзолт, эочны зардал	19,640.0	21,604.0	23,764.4
Дотоод албан томилголт	8,540.0	9,394.0	10,333.4
Гадаад томилголт /арга хэмжээ/	11,100.0	12,210.0	13,431.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хуу</b>	690.0	759.0	834.9
Аудит, баталгаажуулалт, зэрэгтэл тогтоох	245.0	269.5	296.5
Даатгалын үйлчилгээ	340.0	374.0	411.4
Тээврийн хэрэгслийн татвар	83.0	91.3	100.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	22.0	24.2	26.6
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	803,343.6	0.0	0.0

